	1-р түвшний нэгж: 14 муж + 4 хоттой Нийслэл Астана, Алма-Аты, Чимкент, Байконур хотууд. Үүнээс Астана, Алма-Аты, Чимкент хотууд ямар нэгэн мужид харьяалагддаггүй	Бие даасан удирдлага, засаглал, эдийн засаг, санхүүгийн эрх мэдэлтэй
	2-р түвшний нэгж: Мужууд нь дүүргүүдэд хуваагддаг.	
4. Хот суурин газруудын ангилал		
2.1	Улсын ач холбогдол, онцгой статустай хот нь 1 саяас дээш хүн амтай. Мужийн ач холбогдол, статустай хот нь 50 мянгаас дээш хүнтэй Тосгон нь 3000-с дээш хүн амтай бөгөөд хүн	1-р түвшний 4 хотоос бусад хот, суурин газрууд нь засаг захиргааны хувьд мужуудад

<p><i>амын 2/3-оос доошгүй хэсэг нь ХАА-н бус аж үйлдвэр, үйлчилгээ, барилга, дэд бүтцийн салбарт ажиллагсад байна.</i></p>	<p><i>харьяалагдана.</i></p>
---	------------------------------

Япон улс

Япон улс нь аж үйлдвэржилтийн хөгжлийн эхэн үедээ улсаа бүс нутгийн хувьд орон зайн оновчтой төлөвлөлтөөр хөгжүүлж ирсэн. Хүнд аж үйлдвэрийн бүсийг нутгийн баруун өмнөд хэсэгт байгалийн нөөц (ус, нүүрс) болон импорт, экспортын гадаад худалдаанд ойр байршлыг харгалзаж тогтоосон. Тухайлбал Кюсю арлын Китакою хотод ган, эрчим хүч, төмөрлөгийн болон усан онгоцны үйлдвэрийг хөгжүүлж эхэлсэн бол нутгийн хойд болон дунд бүс нутагт хөдөө аж ахуй, үйлчилгээний салбарыг түлхүү хөгжүүлэх бодлого барьж ирсэн. Япон улсын хувьд бүсчилсэн хөгжлийн хуваарь буюу бүсүүдийг тогтоож, тэдгээрт хөрөнгө оруулалт, санхүүгийн ялгавартай бодлого баримтлахдаа экспортод чиглэсэн аж үйлдвэрийн салбаруудын хөгжил болон хот доторхи болон хотуудын хоорондын дэд бүтцийг хөгжүүлэхэд анхаарж ирсэн. Өнөө үед тогтвортой хот байгуулалтыг хөгжүүлэхэд төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, иргэдийг оролцоог дэмжиж, орчин үеийн техник технологи болон ногоон хөгжлийг гол бодлогоо болгон барьж байна. Хүн амын насжилт өндөрсөж, төрөлтийн түвшин буурч, хөдөөнөөс хотыг чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөнтэй холбоотойгоор хөдөөд залуучуудын суурьшлыг дэмжих үүднээс хөдөөд гадаадын харьяат иргэд ажиллаж амьдрахад дэмжлэг үзүүлэхийг зорьж байна.

Хоккайдо бүс нутгийн хөгжлийн цогц бодлогын баримт бичиг: Хоккайдо нь Японы хойд хэсэгт орших ОХУ-ын алс Дорнод хөрш, Хойд Америк, Зүүн Азитай холбосон стратегийн байршилтай хамгийн том арал юм. 1869 онд ойролцоогоор 58 мянган хүн амтай байсан Хоккайдо нь 150 жилийн хөгжлийн хугацаанд жил бүр 5 саяас дээш тоогоор өссөн байна. Япон Улсын засгийн газраас Хоккайдо цогц хөгжлийн төлөвлөгөөг тусгайлан боловсруулсан нь цаг үеийн үндэсний асуудлуудыг шийдвэрлэхэд туслах зорилготой байсан ч үндэсний эдийн засгийг сэргээх, хүн амын ажилгүйдлийн асуудлуудыг шийдвэрлэх, зохих хуваарилалт хийх зэргээр аж үйлдвэрийн бүтэц, эрчим хүч, хүнс тэжээлийн хангамж зэргийг үе шаттайгаар эрчимтэй хөгжүүлэх зорилготой байжээ. Хоккайдо муж нь газар тариалан, загасны аж ахуй, ойн нөөц баялаг, цэвэр ус, салхины эрчим хүч, бусад сэргээгдэх эрчим хүчний нөөц баялагтай. Дотоодын нийт бүтээгдэхүүн (GDP) нь ойролцоогоор 20 триллион иенд хүрч, хойд хилийн боомтын дагуу аялал жуулчлал, амралт цэнгээний газар, хоол хүнс худалдаа үйлчилгээ илүү хөгжсөн нь Япон улсын тогтвортой хөгжилд их хувь нэмэр оруулсаар байна. Бүс нутгийн чадавхийг сайжруулах, тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэхийн тулд засаг захиргааны байгууллагууд, орон нутгийн бизнес, санхүүгийн байгууллагууд, их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаа чухал байр суурь эзэлдэг ба хамтын ажиллагааны нэгдсэн системийн том жишээ тус мужид хэрэгждэг. Түүнээс гадна хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтийг дэмжихийн тулд төлөвлөлтийн шатнаас хэрэгжүүлэх, үнэлэх, сайжруулах замаар бүхий л үе шатанд менежментийн эргэлтийн аргаар зохицуулдаг байна. Бүс нутгийн хөгжлийн бодлогыг хэрэгжилтийг хангахын тулд хүн ам, эдийн засаг, нийгмийн шалгуур үзүүлэлтүүд, бодлогын дэвшилтийг хянан, шаардлагатай тохиолдолд дахин авч үздэг. Мөн хөгжлийн цогц бодлого, түүний хэрэгжүүлэх үе шатыг уян хатан байлгах, шаардлагатай үед нийгмийн эрэлт хэрэгцээ, цаг хугацааны өөрчлөлтөөс харгалзан үзэж, таван жилийн дараа бүрэн хянах, дахин үнэлэх системийг баримталдаг байна.

Өөрөөр хэлбэл бүс нутгийн хөгжлийн төслийг батлахад бус хэрэгжүүлэх, хянах цаашлаад дахин үнэлэлт, дүгнэлт хийдэг цогц систем үйлчилдэг учраас 150 жилийн хугацаанд 10 жилийн давтамжтай 8 дахь удаагийн хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлснээр Хоккайдо бүс нутаг нь өнөөдөр Европын Испани, Швед зэрэг улсуудын хөгжилтэй эн зэрэгцэхээр байгаа билээ.

Тус бүс нутгийн хөгжлийн цогц төслийг тухайн нутаг дэвсгэрийн онцлог шинж чанар, байгалийн нөхцөл, нөөц баялгийг илүү үр ашигтай ашиглах байдлаар хөгжлийн тэргүүлэх чиглэлийг нэгдүгээрт тодорхойлон, тусган хэрэгжүүлж байгаа нь ирээдүйд илүү үнэ цэнэтэй, авуштай санаа байсан.

Мөн бүс нутгийн хөгжлийн цогц төлийг экспертүүдийн бүрэлдэхүүнээр хэлэлцүүлэн, мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээний тусламжтайгаар иргэд, олон нийтээс санал хүсэлтийг авч, тусган үнэлэлт, дүгнэлт хийсний үндсэн дээр эцсийн шатанд батлуулдаг нь олон нийтийн оролцоог сайн хангаж байгаагаас гадна, иргэдийн мэдлэг мэдээлэл сайн байгааг харуулж байлаа.

Япон улсын хөгжлийн цогц төсөлд тусгагдсан үндэсний зорилго, зорилтын дагуу бүс нутгийн хөгжлийн цогц бодлого, томоохон мега төсөл, бичил төслүүдийг нарийвчлан тодорхойлж, үе шаттайгаар хэрэгжүүлдэг нь бүтэц зохион байгуулалт, бодлогын баримт бичгүүдийн хоорондын уялдаа холбоо сайн байгааг харуулж байлаа. Хоккайдо бүс нутгийн хөгжлийн цогц төсөлд байгаль орчинг хамгаалах, ногоон хөгжлийн бодлого, хог хаягдлын дахин боловсруулалт, газар тариалангийн салбарт шинэлэг технологи нэвтрүүлэх зорилтыг илүү глобал түвшинд дэвшүүлж байгаагийн нэг тод жишээ нь хог хаягдал, биомассын үр дүнтэй ашиглалт буюу байгаль орчинд ээлтэй хөдөө аж ахуйг фермийн бүтээгдэхүүнийг дахин боловсруулж үйлдвэрлэхэд чиглэсэн байгууллага байсан. Түүнчлэн, төр, хувийн хэвшлийн түншлэл сайн хөгжсөн ба Хоккайдо бүс нутгийн жижиг дунд үйлдвэрийг дэмжих тухай хууль 1963 онд анх батлагдаж, түүнийг хэрэгжүүлэгч төрийн захиргааны байгууллага 1979 онд байгуулагдсан байна. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжихэд зөвлөгөө өгөх, маркетингийн хийж өгөх, уулзалт зөвлөгөөнд оролцуулах, шаардлагатай тоног төхөөрөмжийг үнэгүй ашиглуулах зэрэг үндсэн 4 функцийн дагуу өвөрмөц системээр үйл ажиллагаа явуулдаг төрийн захиргааны төв байдаг ба Хоккайдо мужид жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв 7 салбар, 35 ажилчинтай үйл ажиллагаа явуулдаг байна. Хоккайдо мужийн хөрөнгө оруулалтын 33 хувь нь дэд бүтцийн хөрөнгө оруулалт эзэлдэг ба цаашид өсөн нэмэгдүүлэх бодлого барьж төмөр зам, хурдны зам, боомт, дамжуулах хоолой зэрэг чухал дэд бүтцийн төслүүдийн тоог нэмэгдүүлэн хэрэгжүүлсэн нь тогтвортой хөгжлийн нэгэн томоохон хэсэг болж байна

Хүснэгт 9. Японы хот суурин газрын ангилал нэгж болон түүний засаг захиргааны хуваарьтай уялдаж буй байдал

№	Нэгжүүд	Тайлбар
5. Засаг захиргааны нэгжийн хуваарийн бүтэц		
	1-р түвшний нэгж: 47 муж + 20 хоттой Нийслэл Токио метрополис хот нь засаг захиргааны хувьд 47 мужийн нэг болдог.	Бие даасан удирдлага, засаглал, эдийн засаг, санхүүгийн эрх мэдэлтэй
	2-р түвшний нэгж:	
6. Хот суурин газруудын ангилал		
2.1	20 Том хот-500 мянгаас дээш хүн амтай	Засаг захиргааны 1-р түвшин болж явдаг. Хот нь 47 мужийн адилаар бие даасан эдийн засаг,

2.2	Төв хот (300 мянгаас дээш хүнтэй, 100 км ² -аас их газар нутагтай) Тусгай хот – 200 мянгаас дээш хүнтэй Хот – 50 мянгаас дээш хүнтэй, хүн амын 60-с их хувь хотын төвд амьдардаг.	удирдлага, эрх мэдэлтэй. Мужуудад харьяалагдана.
2.3	Тосгон	Муж, хотдоо харьяалагддаг.

3.3.1 Хүн амын суурьшлын засаг захиргааны хуваариудаарх дэлхийн улсуудтай харьцуулсан судалгаа

Суурьшмал амьдралыг эрт цогцлоосон, засаглал захиргааны олон жилийн түүхтэй орнууд ХХ зууны сүүлч, шинэ мянганы эхээр засаг захиргааны хуучин тогтолцоогоо үеэ өнгөрөөсөн, хэт жижиг хэсэгт хувааж, улс орны хүч чадлыг тарамдуулсан зэрэг үндэслэлээр шинэчлэл хийж эхлээд байна. Энэ хандлага нь даяаршлын нөлөөгөөр олон улс, бүс нутгийн хүрээнд ч хийгдэж байна. Тухайлбал Европын холбоо нь 27 орныг эгнээндээ нэгтгэж, нэгдсэн мөнгөн дэвсгэрт, хил хязгаартай болж, бүс нутгийн нийгэм, эдийн хөгжлийг хурдасгах нааштай алхам хийсэн.

Мөн Франц улс олон зуунаар уламжилж ирсэн засаг захиргааны 96 нэгжээ 22, Польш 49 нэгжийг 16 болгон цомхотгосон бол Япон, ОХУ, Хятад улс засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийн өөрчлөлтийг аажмаар хэрэгжүүлж байна.

Хүснэгт 10. Дэлхийн газар нутаг томтой зарим улсуудын засаг захиргааны анхдагч болон хоёрдогч нэгжүүдийн тооны харьцуулсан судалгаа

	Улсын нэр	Газар нутгийн хэмжээ, мян.км ²	Хүн амын тоо, саяар	I түвшний нэгжийн тоо	II түвшний нэгжийн тоо	I түвшний нэг нэгжид ногдох хүн амын тоо, саяар	II түвшний 1 нэгжид ногдох хүн амын тоо	I түвшний 1 нэгжид ногдох газрын хэмжээ, мян.км ²	II түвшний 1 нэгжид ногдох газрын хэмжээ, мян.км ²
1	ОХУ	17098	142.9	83	1868	1.7	0.08	206.0	9.2
2	Канад	9985	34.6	13	201	2.7	0.17	768.1	49.7
3	АНУ	9827	312.2	52	3143	6.0	0.10	189.0	3.1
4	Хятад	9597	1339.7	33	330	40.6	4.06	290.8	29.1
5	Бразил	8515	190.7	27	5564	7.1	0.03	315.4	1.5
6	Австрали	7741	22.7	9	562	2.5	0.04	860.1	13.8
7	Энэтхэг	3287	1210.1	35	640	34.6	1.89	93.9	5.1
8	Аргентин	2780	40	22	376	1.8	0.11	126.4	7.4
9	Казахстан	2724	16.5	17	319	1.0	0.05	160.2	8.5
10	Судан	2500	39	15	86	2.6	0.45	166.7	29.1
11	Алжир	2382	36.3	48	553	0.8	0.07	49.6	4.3
12	Ардчилсан Конго	2345	66	10	192	6.6	0.34	234.5	12.2
13	Саудын Арави	2150	27.1	13	118	2.1	0.23	165.4	18.2
14	Мексик	1964	112.3	32	2438	3.5	0.05	61.4	0.8
15	Индонез	1904	237.5	38	430	6.3	0.55	50.1	4.4
16	Ливи	1760	6.3	22		0.3		80.0	
17	Иран	1648	75.6	30	310	2.5	0.24	54.9	5.3
18	Монгол	1564	3.2	22	330	0.1	0.008	71.1	4.7

19	Чад	1284	11.2	22	40	0.5	0.28	58.4	32.1
20	Ангол	1247	19.1	18	163	1.1	0.12	69.3	7.7
21	Мали	1240	14.5	8	49	1.8	0.30	155.0	25.3
22	Этиоп	1104	82.1	11	68	7.5	1.21	100.4	16.2
23	Боливи	1099	10.4	9	112	1.2	0.09	122.1	9.8
24	Мавритани	1030	3.4	12	44	0.3	0.08	85.8	23.4
25	Египет	1001	80.8	29	232	2.8	0.35	34.5	4.3
26	Нигери	924	158.4	37	774	4.3	0.20	25.0	1.2
27	Намиби	823	2.1	13	107	0.2	0.02	63.3	7.7
28	Ботсвана	587	1.8	9	19	0.2	0.09	65.2	30.9
29	Швед	450	9.4	21	289	0.4	0.03	21.4	1.6
30	Финланд	338	5.4	20	86	0.3	0.06	16.9	3.9
31	Норвеги	324	5	22	430	0.2	0.01	14.7	0.8
32	Польш	313	38.2	16	379	2.4	0.10	19.6	0.8
33	Литва	65	3.2	10	60	0.3	0.05	6.5	1.1
34	Эстон	45	1.3	15	226	0.1	0.01	3.0	0.2

Эх сурвалж:

http://en.wikipedia.org/wiki/Table_of_administrative_country_subdivisions_by_country

Монгол Улс нь дэлхийд 1 хүнд ногдох газар нутгийн хэмжээгээр тэргүүлдэг хэрнээ газар нутагтайгаа харьцуулбал харьцангуй олон засаг захиргааны нэгжүүдтэй байгааг Хүснэгт 11-ээс тодорхой харж болохоор байна. Тухайлбал хүн ам цөөнтэй хэрнээ анхдагч нэгжийн (аймаг) тоо 22 байгаа нь Монголоос том нутагтай, хүн ам ихтэй Канад, Австрали, Саудын Арави, Казахстан, Судан, Ардчилсан Конго, Аргентин зэрэг улсаас их байна. Мөн хоёрдогч түвшний засаг захиргааны нэгжийн (сум) тоо Хятад, Казахстан, Судан, Ардчилсан Конго, Саудын Арави, Ливи, Индонез зэрэг улсуудаас их байна. Газар нутаг өргөн уудам, хүн ам цөөнтэй хэрнээ хоёрдогч түвшний засаг захиргааны нэгжид ногдох газар нутгийн дундаж хэмжээгээр дээрх сонгосон 34 улсаас 20 улсын дараа орох бага хэмжээтэй байгаа нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарь дэлхийн улсуудтай харьцуулахад хэт олон хэсэгт хуваагдаж, жижгэрсэн болох нь харагдаж байна.

Скандинавын орнууд: Скандинавын зарим орны туршлагаас харахад жижиг нэгжүүдийг бие даасан нэгж болгохоосоо өмнө тэдгээрийг нэгтгэн хэмжээг нь томсгож, эдийн засгийн баазыг өргөтгөх замаар энэ асуудлыг амжилттай шийдсэн байна. Тухайлбал: Швед Улс 10000-аас доош хүн амтай засаг захиргааны нэгжүүдийг (коммун) сайн дураараар өөр хоорондоо нэгдэх хүртэл улсын төсөв хуваарилахгүй байх шийдвэр гаргаж, нэгдэх эцсийн хугацаа 1980 он гэж 1974 онд хуулиар тогтоож өгчээ. 1974 оны энэ хуулиар 1980 оноос хойш нэгдэж чадаагүй нутаг дэвсгэрийн нэгжүүдийг хүчээр нэгтгэх эрхийг засгийн газарт олгосон байна. Ингээд 1989 он гэхэд сайн дураараа нэгдсэн болон Засгийн газраас хүчээр нэгтгэсэн нэгжүүдийн тоо 2281-ээс 290 болж даруй 8 дахинаар буурсан. Эдгээр коммууудыг нэгтгэсний хамгийн гол ач холбогдол нь бие даан өөрийн нийгэм-эдийн засгийн асуудлаа шийдэж чаддаг хүн амын зохистой төвлөрөл бүхий бүтэц бий болгосон явдал юм.

Хүснэгт 11. Европын зарим улсуудын municipality буюу засаг захиргааны жижиг нэгжүүдийн (сумуудын түвшний) тооны өөрчлөлт


Улсын нэр	1950	2017	Өөрчлөлт, %
Дани	1387	98	-92.9
Литва	581	60	-89.7

Швед	2281	290	-87.3
Грек	5774	1034	-82.1
Их Британи	2028	435	-78.6
Латви	570	118	-79.3
Бельги	2669	589	-77.9
Нидерланд	1015	443	-56.4
Герман	25930	12229	-52.8
Норвеги	744	431	-42.1
Австри	3999	2357	-41.1
Финланд	547	348	-36.4
Испани	9214	8111	-12.0
Швейцарь	3097	2758	-10.9
Эстон	254	227	-10.6
Франц	38814	36682	-5.5
Польш	2399	2418	0.8
Унгар	3122	3153	1.0
Португал	304	308	1.3
Итали	7781	8100	4.1
Румын	2948	3176	7.7
Молдав	881	980	11.2
Чех	4104	6248	52.2

Эх сурвалж: World Bank, 2003; Dexia, 2009/2010 edition in Analytical study on optimal administrative-territorial structure for republic of Moldova

1960-аад оноос Европын орнууд өөрийн бие даасан удирдлагын тогтолцоо бүхий засаг захиргааны жижиг нэгжүүдээ нэгтгэн цөөлж, хүн ам, эдийн засгийн төвлөрлийг дэмжсэн бодлого хэрэгжүүлсэн. Баруун болон Хойд Европын бараг бүх орнууд засаг захиргааны жижиг нэгжүүдээ цөөлжээ (Хүснэгт 12). Зарим орнуудад эдийн засгийн зарчмаар буюу өөрөө өөрийгөө санхүүжүүлэх механизм, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, жижиг нэгжүүдийн эдийн засгийн нөөц, хөрөнгө оруулалтыг нэгтгэн төвлөрүүлж, үр өгөөжийг нь дээшлүүлэх зарчмаар хийгдсэн бол зарим цөөн улсууд шууд Засгийн газрын шууд удирдлагаар энэхүү өөрчлөлтийг хэрэгжүүлсэн байна.


Зураг 3. Засаг захиргааны жижиг нэгжүүдийн (сум) хүн амын дундаж тоо, 2017



Эх сурвалж: *Dexia, EU sub-national governments: 2008 key figures, 2009/2010 edition*

Европын орнуудын бие даасан өөрийн удирдлага бүхий засаг захиргааны дундаж 1 жижиг нэгжид ногдох хүн амын тоо Монгол Улсын дундажтай харьцуулахад харьцангуй өндөр байна. Тодруулбал Монгол Улсын дундаж хөдөөгийн сумын хүн амын тоог харьцуулахад Их Британиас 50, Даниас 16, Шведээс 12, Финландаас 5, Европын холбооны улсуудын дунджаас 2 дахин бага байна (Зураг 3).

Зураг 4. Дэлхийн улсуудын засаг захиргааны анхдагч болон хоёрдогч нэгжүүдийн хуваарь



Эх сурвалж: http://en.wikipedia.org/wiki/File:World_administrative_levels.png

Түүнчлэн дээрх зургаас засаг захиргааны 2 догч түвшний нэгжийн харьцангуй их байгааг дэлхийн улсуудтай харьцуулсан газрын зурагнаас тодорхой харж болохоор байна (Зураг 4).

3.4. Байгалийн нөхцөл, нөөцийн судалгаа


Монгол орны өргөн уудам газар нутагт нь байгаль экологийн хувьд харилцан адилгүй уур амьсгал, экосистемийн төлөвтэй. Энэ агуулгаар Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлийн хөгжлийн ерөнхий төлөвлөлт, бүсчилсэн хөгжлийн бодлого, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн өөрчлөлтийг хийхдээ орон зайн хувьд байгаль орчны дараахь хүчин зүйлүүдийг харгалзан, байгалийс өгөгдсөн нөхцөл байдалтай уялдуулан төлөвлөх хэрэгтэй.


- Уур амьсгалын өөрчлөлт, цаашдын хандлага
- Усны нөөц, түүний тархалт, цаашдын хандлага
- Газрын доройтол, цөлжилт, бэлчээрийн экосистемийн төлөв байдал
- Ойн нөөц, түүний тархалт
- Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ

Монгол орны нутаг дэвсгэр уул, нуруу, уудам тал хосолсон хотгор гүдгэртэй, эх газрын эрс тэс уур амьсгалтай учраас ургамалшлын хувьд өвөрмөгц бөгөөд умраас урагшлахад дэлхийн ургамалшлын 3 үндсэн бүс болох ой, тал хээр, цөлийн бүс байдаг. Эдгээр 3 бүс нь бие биедээ алгуур шилждэг учраас дундаа шилжилтийн буюу завсрын бүс үүсгэдэг бөгөөд ой ба хээрийн бүсийн завсарт уулын ойт хээр, хээр ба цөлийн бүсийн завсарт цөлөрхөг хээрийн бүстэй.

Байгалийн эдгээр бүсүүд дахь дулаан хүйтний горим, жилийн нийлбэр тунадас зэрэг уур амьсгалын харилцан адилгүй хүчин зүйлээс шалтгаалан бэлчээрийн экосистемийн бүтэц, ургамалжилт, биологийн төрөл зүйл зэрэг экологийн систем нь дагаад өөр байдаг. Зураг 5-д Монгол орны тайга, ойт хээр, хээр, цөлөрхөг хээр, цөлийн бүсүүд дээр сумын төвүүд, аймгийн хил, төвийг давхцуулан харууллаа.

Зураг 5. Монгол орны экологийн бүс ба хүн амын нутагшилт, суурьшил





Монгол орны нийт 330 сумдыг экологийн бүсүүдээр ангилан үзвэл тайгын бүсэд 8 сум, ойт хээрийн бүсэд 105 сум, хээрийн бүсэд 127 сум, цөлөрхөг хээрийн бүсэд 68 сум, цөлийн бүсэд 23 сумын нутаг дэвсгэр оршиж байна. Нийт 21 аймгаас ойт хээр, хээр, цөлөрхөг хээр хосолсон Увс, Завхан, Өвөрхангай, Баянхонгор гэсэн 4 аймаг байдаг Сумдын нэг бүрчлэн экологийн бүсээр ангилсан болно.

Экологийн бүсүүд дэх тухайн сумын газарзүйн нөхцөл, экосистем болон уур амьсгалын харилан адилгүй нөхцөл байдал сумдын байгаль орчин, нийгэм, эдийн засагт харилцан адилгүй нөхцөл байдрыг нөхцөлдүүлнэ.

Хүснэгт 12. Сумдын түвшинд байгаль орчин, экологийн доройтлын давамгайлах нөлөө

Экологийн бүс	Сумдын байгаль орчны төлөв байдал, экологид үзүүлэх давамгайлах нөлөө	
	Байгалийн хүчин зүйл	Хүний хүчин зүйл
Тайга	<ul style="list-style-type: none"> Ойн түймэр Ойн хортон шавжийн нөлөө ойн экосистемд нөлөөлж байна 	<ul style="list-style-type: none"> Ойн модны хулгайн тээвэр, зохисгүй ашиглалт
Ойт хээр	<ul style="list-style-type: none"> Ойн түймэр Ойн хортон шавжийн нөлөө ойн экосистемд нөлөөлж байна. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө Дулаарлаас үүдэлтэй гадаргын усны нөлөө, усны нөөцийн хомстол 	<ul style="list-style-type: none"> Бэлчээр, газар ашиглалтын нөлөө давамгайлна. Ойн модны хулгайн тээвэр, зохисгүй ашиглалт Ус ашиглалт, усны аюулгүй байдалд хүний үйл ажиллагаа нөлөөлж байна.
Хээр	<ul style="list-style-type: none"> Энэ бүсэд уур амьсгалын өөрчлөлт, бэлчээр газар ашиглалтын хам нөлөө бэлчээрийн доройтолд илүү нөлөөлж байна. Энэ бүсийн ихэнх нутагт 10 жилийн 1-2 жилд нь ган болох эрэмбэтэй байдаг. Хангайн нуруунаас эх авч говь хээрийн бүсрүү урсдаг томоохон голууд нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд илүү эмзэг, өртөмтгий байна. Цөлжилт хээрийн бүсэд, ялангуяа хээрээс цөлөрхөг хээрийн завсарын бүсэд илүү ажиглагдаж байна 	<ul style="list-style-type: none"> Бэлчээр, газар ашиглалтын нөлөө давамгайлж, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөтэй хам байдлаар нөлөөлж байна. Зарим усны сав газарт уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй нөлөө давамгайлж байна. Хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй цөлжилт
Цөлөрхөг хээр	<ul style="list-style-type: none"> Энэ бүсийн байгаль орчин, экосистемийн тогтвортой байдалд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө илүү давамгайлна. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гангийн эрчим, давтамж нэмэгдэх хандлагатай байгаа. Цөлөрхөг хээрийн 	<ul style="list-style-type: none"> Уул уурхай, ашигт малтмалын олборлолт Хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй цөлжилт Говийн бэлчээрийн даацыг хэтрүүлэн ашигласнаас үүдэлтэй бэлчээрийн экосистемийн

	<p>бүсэд 2 жилийн нэг нь гантай болдог.</p> <ul style="list-style-type: none"> • Харын зуд говь цөлийн бүсэд 2 жил тутамд харын зуд тохиолдог. • Энэ бүсийн нуур, цөөрөм, булаг шанд илүү эмзэг, багасаж байгаа • Гадаргын усны нөөц багатай, зуны хур борооны үед зарим хөв, баянбүрд тогтдог. • Ган, бэлчээрийн хэт ашиглалтаас үүдэлтэй цөлжилт илүү ажиглагдаж байна. 	<p>доройтол нэмэгдэж байна.</p> <ul style="list-style-type: none"> • Сумдын засаг захиргааны хилд баригдсан бэлчээр ашиглалт нь уламжлалт нүүдлээр бэлчээр ашиглах тогтолцоог алдагдуулж байна. Энэ нь бэлчээр доройтох нэг шалтгаан болж байна. • Энэ бүсэд ямааны тоо толгойн нэмэгдэж байгаа нь бэлчээрийн экосистемд нөлөөлж байна. • Нөгөө талаас бод мал цөөрснөөс шалтгаалж малчид говийн харганыг түлшинд илүү ашиглаж байгаа нь тухайн экосистемийн тогтвортой байдалд нөлөөлж байна.
Цөлийн бүс	<ul style="list-style-type: none"> • Энэ бүсийн байгаль орчин, экологийн тогтвортой байдалд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө илүү давамгайлна. • Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гангийн эрчим, давтамж нэмэгдэх хандлагатай байгаа. Цөлөрхөг хээрийн бүсэд 2 жилийн нэг нь гантай болдог. • Харын зуд говь цөлийн бүсэд 2 жил тутамд харын зуд тохиолдог • Цөлийн бүсийн бэлчээрийн экосистем нь уур амьсгалын өөрчлөлтөд илүү эмзэг. • Гадаргын усны нөөц багатай, зуны хур борооны үед зарим хөв, баянбүрд тогтдог. Энэ нь мал амьтын гол үндсэн усны эх үүсвэрийн нэг болно. • Ган, бэлчээрийн хэт ашиглалтаас үүдэлтэй цөлжилт илүү ажиглагдаж байна. 	<ul style="list-style-type: none"> • Сумдын засаг захиргааны хилд баригдсан бэлчээр ашиглалт нь уламжлалт нүүдлээр бэлчээр ашиглах тогтолцоог алдагдуулж байна. Энэ нь бэлчээр доройтох нэг шалтгаан болж байна. • Энэ бүсэд ямааны тоо толгойн нэмэгдэж байгаа нь бэлчээрийн экосистемд нөлөөлж байна. • Нөгөө талаас бод мал цөөрснөөс шалтгаалж малчид говийн харганыг түлшинд илүү ашиглаж байгаа нь тухайн экосистемийн тогтвортой байдалд нөлөөлж байна.


Дээрх газарзүйн онцлог, экологийн бүсээс шалтгаалсан харилцан адилгүй нөхцөл байдлыг хүн амын нутагшилт суурьшлийн хөгжлийн ерөнхий төсөл боловсруулахдаа харгалзан үзэж, уялдуулах шаардлагатай юм.

3.4.1. Усны нөөц ашиглалт ба хүн амын нутагшилт суурьшил

Хуурай газрын хотжилтын хувьд дэлхийн ихэнх томоохон хотууд усны сав, эргийн экосистемийг дагасан хотжиж, суурьшсан байдаг. Хүн амын нутагшилт, суурьшлийн төлөвлөлтөд гадаргын усны тархалт, сүлжээг дагасан суурьшлийг төлөвлөх асуудал чухал байр суурь эзэлнэ.

Улсын болон орон нутгийн зэрэглэлтэй буюу Улаанбаатар хот болон 21 аймгийн төв болон 330 сумын төв, тосгоны байршил нь гадаргын усны тархалтын сүлжээтэй хэрхэн уялдаж дараахь зурагт харууллаа.

Зураг 7. Томоохон гол, нуурын эрэг дагасан хот, суурин газар буюу суурьшил



Хүснэгт 13. Томоохон гол, нуурын эрэг дагасан хот, суурин газар буюу суурьшил

Улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, суурин		Сумын төв, тосгон	
	Хотын нэр, тоо	Хүн ам	Тоо
Томоохон гол, нуурын эрэг дагасан суурьшил	Нийт 15 хот (Өлгий, Ховд, Улаангом, Улиастай, Мөрөн, Цэцэрлэг, Баянхонгор, Арвайхээр, Булган, Эрдэнэт, Дархан, Сүхбаатар, Улаанбаатар, Чингис, Чойбалсан)		Нийт 156 сумын төв (Баян-Өлгий 10, Увс 10, Завхан 12, Хөвсгөл 19, Булган 8, Архангай 14, Орхон 1, Дархан 3, Сэлэнгэ 15, Хэнтий 8, Төв 6, Дорнод 7, Сүхбаатар 1, Дундговь 1, Өмнөговь 1, Өвөрхангай 10, Баянхонгор 10, Говь-Алтай 2, Ховд 11)
Бусад	Нийт 7 хот (Алтай, Зуунмод, Даланзадгад, Мандалговь, Чойр, Сайншанд, Баруун-урт)		Нийт 160 сум, суурин (Баян-Өлгий 1, Увс 6, Завхан 11, Хөвсгөл 4, Булган 7, Сэлэнгэ 3, Хэнтий 13, Төв 17, Дорнод 6, Сүхбаатар 12, Говьсүмбэр 3, Дорноговь 14, Дундговь 13, Өмнөговь 13, Өвөрхангай 9, Баянхонгор 8, Говь-Алтай 10, Ховд 5)


Нийт Улаанбаатар хот болон 21 аймгийн төвүүдээс томоохон гол, нуурын эрэг дагасан хот суурин газар 15 байгаа бол 7 нь ямар нэгэн гадаргын усны сүлжээ даган байгуулагдаагүй байна. Сумын төв, суурин газруудыг гадаргын усны сүлжээтэй уялдуулан үзвэл нийт 156 сумын төв, тосгон гол, нуурын эрэг дагасан суурьшжээ.

Усны сав газар ба уул уурхай, ашигт малтмал

Монгол Улсын Их хурлаас 2007 онд “Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай” 27 дугаар тогтоолын 1-р хавсгалтаар 15 ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод, 2-р хавсралтаар нийт 39 ашигт малтмалын ордуудын нөөцийг нарийвчлан тогтоож, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах эсэх тухай саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж шийдвэрлүүлж байхыг Засгийн газар даалгасан байдаг¹³.


Монгол улсын хөгжилд багагүй үүрэг, роль гүйцэтгэх эдгээр ашигт малтмалын 54 ордын байршлыг улсын хэмжээнд хилийг нь тогтоосон 29 голын сав газрын гадаргын болон газрын доорх усны ашиглаж болох усны нөөцтэй орон зайн хувьд давхцуулан харууллаа.

Зураг 8. Усны сав газруудаарх хот, суурин газруудын болон усны ордуудын байршил



Усны нөөцийн ангилал	Усны ашиглах боломжит нөөцийн тоон интервал, сая м ³	Усны сав газар, тухайн усны сав газрын дугаараар	Аймгийн төв, хот, тоо	Сумын төв, тосгон, тоо
Маш бага	Гадаргын усны бараг нөөцгүй	25, 20, 16, 17, 18	4	79
Бага	< 80	26, 27, 29, 24, 5, 6, 7, 23, 22, 21, 19, 9, 10, 13, 14, 3,	11	154
Дунд	80 – 160	4, 28, 15	3	28
Их	160 – 240	8, 11	4	27
Маш их	240 <	9, 1, 2		25

¹³ “Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамруулах тухай” УИХ-ын 2007 оны 27 дугаар тогтоол. Улаанбаатар



Аймгийн төв, нийслэл

- ★ 15000 - доош хүн амтай 3 хот
- ★ 15001 - 50000 хүн амтай 16 хот
- ★ 50001 - дээш хүн амтай 3 хот

Сум, суурин

- 3000 - доош хүн амтай 174 сум, суурин
- 3001 - 10000 хүн амтай 131 сум, суурин
- 10001 - дээш хүн амтай 6 сум, суурин

Гүний усны ашиглах боломжит нөөц, сая м.куб

- 0.00 - 25.00 нөөцтэй 20 усны сав газар
- 25.01 - 50.00 нөөцтэй 4 усны сав газар
- 50.01 - 75.00 нөөцтэй 3 усны сав газар
- 75.01 - 100.00 нөөцтэй 1 усны сав газар
- 100.01 - 142.80 нөөцтэй 1 усны сав газар

Усны сав газрын нэр

1 Сэлэнгэ	16 Мэнэнгийн тал
2 Хөвсгөл	17 Умард говийн гуваат-Халхынцундад
3 Шишхэд	18 Галба-Өөш - Долоодын говь
4 Дэлгэрмөрөн	19 Онги
5 Идэр	20 Алтайн өвөр говь
6 Чулуут	21 Тааз
7 Хануй	22 Орог нуур - Туй
8 Орхон	23 Боонцагаан нуур - Байдраг
9 Туул	24 Хяргас нуур - Завхан
10 Хараа	25 Хүйсийн гол - Цэнэг нуур
11 Ерөө	26 Уенч - Бодонч
12 Онон	27 Булган
13 Увс	28 Хар нуур - Ховд
14 Хэрлэн	29 Увс нуур - Тэс
15 Буйр нуур - Халх	


Хүснэгт 14. Усны сав газрын нөөц ба түүний дагуух суурин газруудын тоо

Усны нөөцийн ангилал	Усны ашиглах боломжит нөөцийн тоон интервал, сая м ³	Усны сав газар, тухайн усны сав газрын дугаараар	Аймгийн төв, хот, тоо	Сумын төв, тосгон, тоо
Маш бага	< 25.0	2, 3, 4, 5, 6, 7, 11, 12, 15, 16, 19, 21, 22, 23, 24, 25, 26, 27, 28, 29	9	145
Бага	25 – 50	8, 17, 14, 13	6	93
Дунд	50 – 75	10, 18, 20	1	45
Их	75 – 100	1	1	11
Маш их	100 <	9	2	19

3.4.2. Байгалийн гамшигт үзэгдэл болон түүний хүн амд үзүүлж буй нөлөө

Байгалийн гамшигт үзэгдлийг геофизикийн, усны, цаг уурын, уур амьсгалын, биологийн гэж 5 ангилдаг байна. Үүнээс усны, цаг уурын, уур амьсгалын гамшигт үзэгдлүүдийг ус цаг уурын гамшигт үзэгдэл хэмээн үздэг. Сүүлийн жилүүдэд байгалийн гамшигт үзэгдэл, үүний дотор ус цаг уурын аюултай болон гамшигт үзэгдлийн давтагдал ихсэж байгааг дэлхийн цаг агаарын дулаарал, уур амьсгалын өөрчлөлттэй холбон тайлбарлаж байна. Тухайлбал, агаар мандлын гаралтай аюултай болон гамшигт үзэгдлийн тоо ихсэж, 1990-2000 онд жилд дунджаар 30 орчим аюултай үзэгдэл ажиглагддаг байсан бол 2001-2016 онд даруй 2 дахин нэмэгджээ /Зураг 11/ [Мижиддорж.Р нар 2007].

Зураг 12. Монгол оронд ажиглагдсан ус, цаг уурын аюултай болон гамшигт үзэгдлийн тоо, 1989-2016 он



Эх сурвалж:

2012-2018 онд хот суурин газруудад ус, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн улмаас нийт 35,1 тэрбум төгрөгийн хохирол учруулсан байна /Хүснэгт 2,3/ [1].



Зураг. Дорноговь аймгийн Айраг сумын төвийн айлуудын усны үерт автсан байдал. 2018.08.05

Айраг сумын төвийг олон нуурын хотгор гэж үздэг учраас хонхор нам дор газар байрладаг байна. Харин суурьшлын бүсийг нам дор газар буруу тогтоож, цахилгааны дэд бүтцийг байгуулснаас болж айлууд үерт автсан

2018 оны 8-р сарын эхэнд болсон үерийн гамшигт 8 хүн амь үрэгдэж, 70 хүн бэртсэн (Б.Ууганбаяр, 2018, ОБЕГ).



Зураг. Баян-Өлгий аймгийн Өлгий хот ширүүн аадар борооны усны уруйн үерт автсан байдал. 2018.08.04

Зуд болон түймрээс бусад аюултай болон гамшигт үзэгдлийн хохирол учруулсан байдлыг үзэгдэл тус бүрээр харьцуулж үзэхэд 2012-2018 онд уруйн үер 90%-98%-ийг эзэлж байгаа нь хот суурин газруудад илүү их аюул гамшиг тарих эрсдлийг нэмэгдүүлж байна.

Хүснэгт. Байгалийн гамшигт үзэгдлүүдийн хот, суурин газруудад үзүүлсэн нөлөө

Үзэгдлийн нэр	Хамарсан хот суурин	Сар, өдөр	Хохирол, сая төгрөгөөр
2012 он			
Ширүүн аадар бороо, уруйн үер	Эрдэнэт хот	7.14	8300
Хүчтэй салхи шуурга	Говь-Алтай аймгийн зарим сумын төв	2.05	120
2013 он			
Ширүүн аадар бороо, мөндөр	Сэлэнгэ аймгийн зарим сумын төвүүд	7.04	3010
2014 он			
Хүчтэй салхи, мөндөр	Архангай аймгийн Хашаат сумын төв	7.26	413
Аадар бороо	Говь-Алтай аймгийн Алтай хот	6.27	715
2015 он			
Их цас, хүчтэй салхи шуурга	Ихэнхи нутаг	4.03-04	5266
2016 он			
Аадар бороо	Увс аймгийн Улаангом хот	8.07	1700
Аадар бороо, мөндөр	Баян-Өлгий аймгийн Өлгий хот	7.1	2256
2018 он			
Аадар бороо, уруйн үер	Дорноговь аймгийн Айраг сумын төв	8.05	Үерт 8 хүн нас барж, 130 хүн бэртэж, 1200 гаруй айл өрх усанд

Аадар бороо, уруйн үер	Баян-Өлгий аймгийн Өлгий хот	автаж, 500 гаруй хашаа урссан. Мөн төмөр замд эвдрэл гарч, нийт 21 тэрбум төгрөгийн хохирол учирсан.
Аадар бороо, уруйн үер	Хөвсгөл аймгийн Их-Уул сумын төв	

Шороон шуурга. Шороон шуургатай өдрийн тоо 1960-1980-аад оны дунд хүртэл бараг 3 дахин өсч, (Natsagdorj et all 2003) 2000 он хүртэл бага зэрэг буурч 2000 оноос хойш буурах хандлагатай байна. 2009 оноос шороон шуурганы давтагдал буурч байгаа нь хаврын улиралд хур тунадас ахиу орсон, түүнчлэн хүчтэй салхи үүсэх агаар мандлын хүчин зүйлийн нөлөө харьцангуй бага байсантай холбоотой юм. Тухайлбал 1970-аад онд шороон шуургатай өдрийн тоо 30 байсан бол 2000 оноос хойш 40-50 болж өссөн. Манай орны өмнөд хэсгийн говийн бүс нутагт тэр дундаа хүн амын суурьшил бүхий Замын-Үүд, Сайншанд, Даланзадгад зэрэг хотод шороон шуурга нь элсний нүүдэлд хүргэж, зарим зам, барилга байгууламж элсэнд дарагдахад хүргэж буй бол Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд суманд уул уурхайн олборлолт болон тээвэрлэлттэй холбоотойгоор нүүрсний тортог, зүамын шороотой шороон шуурга, элсний нүүдэл нь холилдож, агаарын бохирдлыг ихээр нэмэгдүүлж байна. Говь, хээрийн бүсийн 145 сумын төв суурин газар элсний нүүдэлд өртсөн байна (Цөлжилттэй тэмцэх Үндэсний хөтөлбөр 2010). Замын-Үүд жилдээ тэрбум гаруй төгрөгийг элсний нүүдэлд өртсөн талбайг цэвэрлэх, элсийг зөөхөд зарцуулдаг. Иймд элс бэхжүүлэх дэвшилтэт шинэ арга технологийг нэвтрүүлэх шаардлагатай байна. Сүүлийн үеийн мэдээгээр Монгол орны нийт газрын нутгийн 78.6 хувь нь цөлжсөн гэсэн мэдээ байгаа. Үүний 10-аад хувь нь элсний нүүлт хөдөлгөөнтэй холбоотой цөлжилт. Ялангуяа баруун монголын нууруудын хөндий, их нууруудын хотгор, өмнийн говийн томоохон элсэн тарамууд байгаа. Эдгээрийн нүүлт хөдөлгөөнийг сааруулахын ач холбогдол нь их. Яагаад гэвэл элсэнд дарагдсан бэлчээр дахин ашиглагдахгүй орхигддог. Элс бэхжүүлэх технологи экологийн тэнцвэрийг хадгалах боломжтой.

Мөн цөлжилтийн нэн хүчтэй (5 хувь), хүчтэй (18.5 хувь) зэрэглэлд хамрагдах газруудад мод тарих, ургамалжуулах, хөв цөөрөм байгуулах, нийгмийн чухал ач холбогдолтой дэд бүтэц, барилга байгууламж, суурин газрыг элсний нүүлт хөдөлгөөн, газрын элэгдэл, эвдрэлээс хамгаалах бодит арга хэмжээг зураг төсөл, төлөвлөгөөний дагуу жил бүр зохион байгуулах гарч байна.

3.4.3. Хүрээлэн буй орчны бохирдол ба хүн амын амьдрах орчинд үзүүлж буй нөлөө

Сүүлийн жилүүдэд хот, суурин газрын хүн ам, автомашины тоо ихээхэн өсч, үйлдвэрлэл, үйлчилгээ нэмэгдэхийн хирээр агаар, хөрс, усны бохирдлын түвшин зөвшөөрөгдөх хэмжээнээс давах тохиолдол тогтмол гарах болжээ. Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн жилийн дундаж агууламж хүлцэх агууламжаас 2015 онд 2,4 дахин, 2016 онд 3 дахин их гарчээ. Орон нутгийн хэмжээнд авч үзвэл Баянхонгор, Даланзадгадад хүлцэх агууламжаас 1,6-1,8 дахин их байна.

Агаарын бохирдол нь зөвхөн Улаанбаатарын асуудал биш болоод удаж байна. Баянхонгор Аймагт 2018 оны 12-р сарын 8-нд НҮБ-ын Хүүхдийн Сангийн Суурин төлөөлөгч Алекс Хайкенсын PM2.5 хэмжигч нь 999 microgram/m3 буюу ДЭМБ-ын тогтоосон стандартаас даруй 40 дахин илүү бохирдолтой гэж заасан. Мөн Зүүнхараа хот

агаарын бохирдол ихтэй байна. Учир нь тус хотын төсвийн болон хувийн хэвшлийн байгууллагууд нэгдсэн халаалтын системгүй бөгөөд бүгд тус тусдаа уурын зуухтай, мөн гэр хорооллын утаа нэмэгдэж буй нь агаарын бохирдлын гол эх үүсвэр болж байна.

Зураг. Баянхонгор хотын агаарын бохирдлын зураг. 2018.12.08



Нийслэл Улаанбаатар хотын хүрээлэн буй орчны бохирдол


Нийслэлийн агаар, хөрс, ус, дуу чимээ зэрэг орчны бохирдол хүн амын өсөлтийг дагаад жилээс жилд нэмэгдэж гамшгийн түвшинд хүрээд байна.

Агаарын бохирдол: ДЭМБ-аас 600 гаруй хотуудад хийсэн судалгаагаар Улаанбаатар хот дэлхийн хамгийн их агаарын бохирдолтой хот болжээ.



Эх сурвалж: World Health Organization. 2017. World cities air pollution

Тухайлбал дэлхийн 1100 гаруй хотоос 10 хүртэл микрограмм диаметртэй тоосонцорын бохирдлоор дэлхийд 2-рт, 2.5 хүртэл микрограмм диаметртэй тоосонцорын бохирдлоор дэлхийд тэргүүлж байхад хамгийн бага бохирдолтой хотуудын түвшин Улаанбаатарынхаас 15-30 дахин бага бохирдолтой байна.



Эх сурвалж: World Health Organization. 2017. World cities air pollution

Усны бохирдол: Геоэкологийн хүрээлэнгийн эрдэмтдийн хийсэн судалгаагаар Туул голын гадаргын усны бохирдол Лүн сумын гүүр хүрч цэвэршдэг байсан бол одоо Дархан хот хүрч цэвэршдэг болсон нь бохирдол ихэссэнийг харуулж байна¹⁴. Нийслэлийн гадаргын ус нянгын үзүүлэлтээр 5 дахин их буюу дээд зэргийн бохирдолтой болсон байна. Мөн **гүний усны** бохирдол ч хөрсний бохирдлын нөлөөнөөс хамаарч нэмэгдэж байна. Нийслэлийн гүний худгийн 30,7 хувь нь нянгын бохирдолтой байна. Мөн хөрсний бохирдол гэр хороололд ихэссэн бөгөөд 100 айл орчмын зарим худгуудаас бохирдлын нян гарсан.

Хөрсний бохирдол:

Гэр хорооллын хөрсний бохирдол: НЭМГ-аас орчны бохирдлын түвшинг тогтоохын тулд гэр хорооллын айл өрхийн бие засах газар, бохир усны цооногийн шаардлага хангасан байдал, ундны усны хангамж, халуун усны хүртээмжийн судалгааны асуумж боловсруулан есөн дүүргийн 62 хорооны 97 мянган өрхийг судалгаанд хамруулжээ. Уг судалгаагаар гэр хорооллын өрхийн 85 хувь нь стандартын шаардлага хангаагүй бие засах газартай¹⁵. 2006 онд Улаанбаатарын хөрсний бохирдол 95 хувь буюу нянгийн бохирдолтын хэмжээнд хүрсэн гэх судалгаа гарч байжээ. Энэ нь байх ёстой хэмжээнээсээ 10-16 дахин их байна гэсэн үг юм. Хэдхэн жилийн өмнө хөрсний болон агаарын бохирдолд хийсэн шалгалтын дүнгээр Улаанбаатар хотод амьдарч байгаа гэр хорооллын айл өрхүүдийн 67 хувь нь стандартын шаардлага хангаагүй бие засах газартай, 34.5 хувь нь огт бие засах газаргүй, бохир усны цооноггүй байгаа нь тогтоогджээ.

Хортой, хүнд металлуудын бохирдол: Нийслэлийн дүүргүүдийн хөрсөн дэх бохирдолд хортой, хүнд элементүүдийн агууламж буюу бохирдлын хэмжээ өндөр байна. Тухайлбал хүнцэлийн хэмжээ 7 дүүргээс 6 дүүрэгт, хар тугалгын хэмжээ Сүхбаатар дүүрэгт, зэсийн хөрсөн дэх агууламж Сонгинохайрхан, Налайх дүүрэгт, ураны агууламж Баянгол дүүргийн гүний усанд тус тус стандарт хэмжээнээс хэтэрсэн нь хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх түвшинд хүрсэн байна.

¹⁴ Л.Жанчивдорж. 2012. Туул гол: Экологийн өөрчлөлт, усны менежментийн асуудал.

¹⁵ Нийслэлийн эрүүл мэндийн газар. 2011. Гэр хорооллын орчны бохирдлын судалгаа. Б.Оюунчимэг нар

Дуу чимээний бохирдол: Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын судалгаагаар хүний эрүүл мэндэд дуу чимээний бохирдлын сөргөөр нөлөөлөх түвшинг 55-аас дээш децибелээр тогтоосон байдаг. Европын дуу чимээний бохирдол хамгийн ихтэй 1 саяас илүү хүн амтай Братислав, Парис, Варшав зэрэг хотод 55-60 децибел байхад¹⁶ нийслэлийн хөл хөдөлгөөн ихтэй, Олон улсын худалдааны төв гэхээсээ хот, хөдөөгийнхний уулзар болсон “Нарантуул” зах болон Улаанбаатартаа хүн ам хамгийн ихээр шигүү суурьшсан III-IV хороолол зэрэг 2-3 газарт хийсэн шилжилтээр хотын дуу чимээ 75-80 децибалд хүрчээ.

3.4.4. Уур амьсгалын өөрчлөлт ба хүн амын суурьшилд үзүүлэх нөлөө

Уур амьсгалын өөрчлөлт: Монгол Улсын нутаг дээрх цаг уурын өртөөдийн 1940-2016 оны хооронд тасралтгүй хийсэн ажиглалтын мэдээгээр [БОУАСУАӨТХН, 2017] газрын гадарга орчмын жилийн дундаж агаарын температур 1988 оноос эрчимтэй дулаарсан бөгөөд дулааралт +2.2°C/76 жил гарсан болно /Зураг а/. Сүүлийн 70 гаруй жилийн хугацаанд жилийн нийлбэр хур тунадасны хэмжээ маш их хэлбэлзэлтэй байсан хэдий ч өссөн, буурсан тодорхой хандлага илрээгүй болно. Харин 5 жилээр дунджилсан хур тунадасны өөрчлөлтийг авч үзэхэд 1997-2011 он хүртэл хугацаанд хур тунадас бага байсан байна. /Зураг б/.

Энэхүү хур тунадас татруу үед (1997-2011) 300 С-аас давсан халуун өдрийн тоо эрс нэмэгдсэнээр потенциал ууршилт нэмэгдэж, улмаар илүү их хуурайшилт явагдан чийгийн баланс олон жилээр хасах утгатай болж, их хэмжээгээр багасаж Монгол оронд урьд өмнө буюу сүүлийн 75 жилд тохиолдож байгаагүй их хуурайшилт явагдсан. Энэ их хуурайшилтын үед олон гол горхи ширгэсэн [Мижиддорж.Р нар 2007].


Дүгнэлт: Монгол орон нь эх газрын эрс тэс, хуурай гандуу уур амьсгалтай, усны нөөцөөр хомс, ургамлын нөмрөг сийрэг бөгөөд экосистемийн болон биологийн төрөл зүйлээр төдийлөн баян биш юм. Уур амьсгалын өөрчлөлт болон уул уурхай, хөдөө аж ахуй, хотжилт, аялал жуулчлал зэрэг хүний зохисгүй үйл ажиллагааны улмаас байгалийн нөөц хомсдож доройтох байдал сүүлийн жилүүдэд нэмэгдэж байна. Хот, суурин газрын хүн ам өсөхийн хирээр хэрэглээ нь улам хурдацтай өсөж, экосистемийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглээ болон хүнээс үүдэлтэй хог хаягдлын хэмжээ жилээс жилд хурдацтай өсч байна. Манай орны байгаль, нийгэм эдийн засгийн салбарын уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн үнэлгээний судалгааны үр дүнгээс үзэхэд сөрөг нөлөөлөл нь давамгайлахаар байна.

Үүнд: Сөрөг үр дагавар:

- Зуны халуун өдрийн тоо олшрох;
- Ууршил эрчимшиж, газрын хөрсөнд чийг хуримтлагдах хэмжээ буурах;
- Зуны хур тунадас татарч, шиврээ биш аадар хэлбэрээр зонхилон орох;
- Хур тунадасны улирлын шилжилт болж, өвөл орох цасны хэмжээ нэмэгдэх;
- Хөрсний чийгийн хэмжээ буурч, гол горхийн урсац бүрэлдэхэд сөргөөр нөлөөлөх
- Мөнх цас хумигдаж, мөсөн гол татарсны улмаас тэдгээрээс тэжээл авдаг булаг шанд, гол горхины ус багасах, ширгэх аюул нүүрлэх;
- Байгалийн бүс хойшоо шилжиж, бүслүүр дээшээ огших;

¹⁶ European Environment Agency, <http://www.eubusiness.com/news-eu/health-noise.145>

- Ойн бүс хойт хил рүү шахагдаж, уулын царамд тулж талбай нь хумигдаж болзошгүй;
- Говь цөлийн бүс хойшоо тэлж ургамлан нөмрөг сэмэрч эхэлж болзошгүй;
- Бэлчээрийн ургамлын зүйлийн бүрдэлд өөрчлөлт орж, мал бэлчэээрлэлтийн ачаалал даах чадавхи сульдаж болзошгүй;
- Бэлчээрийн ургамлын ургалтын үе шатанд өөрчлөлт орж мал давжаарч, мах сүү, үс ноосны гарц, чанарт нөлөөлж ашиг шим нь буурч болзошгүй;
- Усалгаагүй газар тариалангийн бүс нутагт хуурайшилтын улмаас ургац буурах, эдийн засгийн үр ашиг багасах эрсдэл нэмэгдэж болзошгүй;
- Мөнх цэвдэг хайлснаас зарим газар ой мод, бутан төгөл хатаж устах тохиолдол нэмэгдэх;
- Мөнх цэвдэг хайлсны улмаас байшин барилга суух, зам гүүр эвдрэх гэмтэх тохиолдол гарах магадлал нэмэгдэх талтай;
- Дулаан бүсийн нутагшмал өвчин эмгэгийн хил ойртож, эрсдэл нэмэгдэж болзошгүй.




Эх сурвалж: Байгаль орчны төлөв байдлын тайлан 2012

Дэлхийн түвшинд дулаарал 0.85°C байхад Монгол оронд 2.07°C байгаа нь дунджаас 2.4 дахин их юм. Монгол Улс уур амьсгалын эрсдэлд өртөмтгий (100 гаруй орноос 8-рт) байгаа өнөөгийн нөхцөлд ажиллах хүчний 29.8 хувийг шингээж, эдийн засгийн 15 хувийг үйлдвэрлэж байгаа хөдөө аж ахуйн салбарын дасан зохицох чадавхийг бэхжүүлэх нь орон нутгийн иргэдийн амьжиргааг доройтуулахгүй байхад чухал үүргийг гүйцэтгэнэ.

Монгол орны өргөн уудам газар нутагт хүн амын нутагшилт, суурьшлийн орон зайн төлөвлөлтийг өнгөрсөн 70 гаруй жилийн уур амьсгалын өөрчлөлт, цаашдын хандлагатай уялдуулан авч үзэх нь хот, суурин газрын тогтвортой хөгжлийг хангах, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, дасан зохицох үндсэн нөхцөл болно.

Зураг х. 1961-2011 оны хооронд илүү дулаарч буй бүс нутаг ба Хүн амын нутагшилт, суурьшил




Хүснэгт х. Уур амьсгалын өөрчлөлтөд илүү эмзэг хот, суурин газар ба хүн амын суурьшил


Агаарын температурын өөрчлөлт, 0С, 1940-2011	Улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот	Сумын төв, тосгон	Тухайн бүсэд суурьшиж буй хүн амын тоо (≈ - оор)
0-оос 1 0С хүртэл дулаарсан бүсэд	1 хот (Чингис хот)	Нийт 8 сум, суурин	
1-ээс 1.50С хүртэл дулаарсан бүсэд	Нийт 5 хот (Булган, Сайншанд, Алтай, Улиастай, Эрдэнэт хот)	Нийт 111 сум, суурин	
1.5-аас 20С хүртэл дулаарсан бүсэд	Нийт 6 хот (Чойбалсан, Цэцэрлэг, Өлгий, Дархан, Арвайхээр, Чойр хот)	Нийт 142 сум, суурин	
2-оос 2.50С хүртэл дулаарсан бүсэд	Нийт 8 хот (Улаанбаатар, Зуун-мод, Баруун-урт, Мандалговь, Баянхонгор, Сүхбаатар, Улаангом, Даланзадгад хот)	Нийт 45 сум, суурин	

2.5-аас 3 ⁰ C хүртэл дулаарсан бүсэд	Нийт 2 хот (Ховд, Мөрөн хот)	Нийт 10 сум, суурин	
Нийт	22	316	



Өнгөрсөн 70 гаруй жилийн хугацаанд орон зайн хувьд уур амьсгалын өөрчлөлт 2⁰C-ээс дээш дулаарч буй бүсэд Улаанбаатар болон 9 хот буюу аймгийн төв, сумдаас 55 сумын төв оршиж байна. Эдгээр нийт хүн амын 60 хувийг эзлэх хот, сумын төвд амьдарч байгаа хүн ам нь уур амьсгалын өөрчлөлт, дулаараас үүдэлтэй эрсдэл өндөртэй бүсэд суурьшиж байна.





Монгол орны уур амьсгалын системд ажиглагдаж буй өөрчлөлтүүдээс дурьдвал

- Агаарын температурын өөрчлөлтийг улирлаар авч үзвэл **өвлийн улиралд** сулхан хүйтрэлт илэрч, зуны улиралд дулааралтын эрчимшил нэмэгджээ. хамгийн дулаан 10 жил 1997 оноос хойш тохиолдож, 26⁰C-ээс дээш халуун өдрийн тоо 5-28 хоногоор огцом нэмэгдэж, их хүйтэн өдрийн тоо 8-27 хоногоор цөөрсөн байна.
- Зуны хур тунадсны орон зайн хуваарилалт, хэмжээ, бүтэц өөрчлөгдөж байна. Монгол орны жилийн хур тунадасны 92 хувийг дулаан улирлын тунадас, 3 хүрэхгүй хувийг өвлийн тундас эзэлдэг. Жилийн нийлбэр тунадас сүүлийн 10-15 жилд буурсан хэдий ч өвлийн тундас бага хэмжээгээр нэмэгдсэн байна.
- 1961-2009 оны хооронд дэвсгэр гадаргын нийлбэр ууршиц 122 мм-ээр нэмэгдсэн байхад энэ хугацаанд дулааны улирлын хур тунадас 35 мм-ээр буурсан байна.
- Газрын гадаргын ууршилт, хур тунадасны өсөлтөөс 6-10 дахин их байгаа нь хуурайшилт, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй цөлжилт, газрын доройтолыг нэмэгдүүлж байна.
- Ургамал ургаж эхлэх үеийн Хур тунадасны хэмжээ говийн бүсэд багассан, нийт хур борооны дотор түр зуурын, аадар хур бороо нэмэгдсэн, Хангайн бүсэд дулааны температур багассанаар ургамлын ургаж эхлэх хугацаа 50-60 хоногоор ухарсан.

3.4.5. Амралт сувилал, аялал жуулчлалын судалгаа

Аялал жуулчлалын тухай хууль, Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, эрхзүйн орчны судалгаа, Монгол Улсын болон гадаадын иргэдийн Монгол Улсын хилээр нэвтэрсэн иргэдийн судалгаа, боомтуудаар, гадаадын зорчигчдын тоо бүсээр, жуулчдын бааз, зочид буудалын тоо, аялал жуулчлалын голлох маршрут, амралт рашаан сувилалын судалгаа, томоохон рашаанууд аймгаар, Дэлхийн эдийн засгийн форумас гаргасан

“Аялал жуулчлалын өрсөлдөх чадварын индекс”-ын судалгаа, Монгол улсад зохион байгуулагддаг эвент арга хэмжээний судалгаа, аялал жуулчлалын томоохон төсөл, хөтөлбөрүүдийг цуглуулах судлах ажлыг гүйцэтгэж байна.

Манай улсын аялал жуулчлалын салбар албан ёсоор 1954 онд үүсэн жар гаруй жилийн түүхтэй салбар бөгөөд анх төрийн өмчит “Жуулчин” компани үйл ажиллагаа явуулж эхэлсэн бол өдгөө уг салбарт 600 гаруй тур оператор компани, 370 зочид буудал, 300 гаруй жуулчны бааз үйл ажиллагаа явуулж, нийт 50 мянга гаруй хүн тус салбарт ажиллаж байна.

2017 оны байдлаар аялал жуулчлалын салбарын орлого нь ДНБ-ий 5.4 хувийг бүрдүүлж, 400 сая ам.долларын орлого олж, өмнөх оныхоос орлого нь 22 хувиар өсч, жилд дунджаар 400 мянга орчим жуулчин хүлээн авч байна. Манай улсын аялал жуулчлалын хөгжлийн давуу болоод сул талыг дараах байдлаар үнэлж байна.

Хөгжлийн давуу талууд:

- Нүүдэлчдийн хосгүй ёс заншил, уламжлал, түүх соёлын давтагдашгүй үнэт өв, унаган төрхөө харьцангуй сайн хадгалж үлдсэн үзэсгэлэнт газар нутаг;
- Дэлхийд алдар цуугаа дуурсгасан их эзэн Чингис хаан, түүний өв залгамжлагчдын үлдээсэн түүхийн өв;
- Монголчуудын зочломтгой, найрсаг зан чанар.

Хөгжлийн сул талууд:

- Аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэр төрөл цөөн, үнэ өндөр, өөр хоорондоо ялгаа багатай;
- Дэд бүтэц муу, жуулчин тээвэрлэх, хүлээн авах хүчин чадал бага;
- Монгол орны эрс тэс цаг уурын байдал;
- Мэргэжлийн ажиллах хүчин дутмаг, аялал жуулчлалын салбарын сургалт, судалгааны чанар хангалтгүй;
- Жуулчдын статистик бүртгэл хөтлөх, судалгаа хийх тогтолцоо сул, мэдээллийн нэгдсэн сан байхгүй;
- Жуулчдыг татахад чиглэсэн маркетинг, гадаад сурталчилгааны ажил хангалтгүй;
- Үйлчилгээний стандарт, аюулгүй байдал хангагдаагүй.

Монгол Улсын хувьд цаашид аялал жуулчлалын салбарын тогтвортой хөгжлийг хангаж, хөтөлбөрийн зорилтуудыг амжилттай хэрэгжүүлэн, Ази, Номхон далайн орнуудыг зорьж байгаа жуулчдын урсгалыг татсанаар 2025 он гэхэд жуулчдын тоог 2 саяд, Дэлхийн аялал жуулчлалын зөвлөлөөс гаргасан аялал жуулчлалын өрсөлдөх чадварын үзүүлэлтийг 99 дүгээр байрнаас 85 дугаар байранд хүргэх боломжтой.

3.5. Хот байгуулалтын инженер-геологийн нөхцөл


3.5.1 Цэвдгийн хүн амын суурьшил болон хот байгуулалтад үзүүлэх нөлөө

Монгол орны цэвдгийн тархалт


Монгол оронд тархсан цэвдэг ба мөтслөгийн газарзүйн тархалтын зүй тогтол, ач холбогдол, түүний дулаан, чийгийн горимын хувьсал өөрчлөлт болон экосистемд

үзүүлэх нөлөөг судлах нь хүн амын нутагшилт суурьшил, хот байгуулалтад чухал үүрэгтэй. Цэвдгийг аж ахуйд зүй зохистой ашиглах, инженерийн байгууламжид үзүүлэх сөрөг нөлөөг багасгах ба тооцох, заавар, зөвлөмж өгөх, аргачлал, стандарт зэргийг боловсруулах нь салбарын бас нэг үүрэг мөн. Монгол орны мөнхцэвдэгийн мониторинг хяналтыг ШУА-ийн Газарзүй-геоэкологийн хүрээлэнгийн Цэвдэг судлалын сектор 100 орчим цэгт явуулж, хээрийн хэмжилт судалгааг (жил бүр 9000-11000 км) хийж байна.

Зураг. Монгол орны цэвдгийн тархалтын зураг, мужлалтаар 2016 он




Тэг буюу түнээс доош градус 2 оос дээш жил орших ул хөрсийг (ус, мөс, органик материал, хурдас чулуулаг г.м) цэвдэг гэнэ. Дэлхийн 48 улсын газар нутагт ямар нэгэн хэмжээтэй цэвдэг тархсан байх боловч түүний нийт талбайн **95 орчим хувь нь 5 улсын газар нутагт** оногддог. Цэвдгийн тархалтаараа ОХУ, Канад, Хятад, АНУ-ын дараа **тавдугаарт Монгол улс ордог** (Tingjun Zhang, 2006). Монгол орны цэвдгийн тархалтын хувьд Алтай, Хангай, Хэнтий, Хөвсгөлийн уулсын өндөрлөг хэсэгт **цэвдэг** ихэвчлэн тархах ба энэ нь манай орны нийт газар нутгийн 29.3 хувийг эзэлнэ.



Жилийн дундаж агаарын температур, өндрийн зүй тогтол, ургамлан бүрхэвч зэрэг нь Монгол оронд орчин үеийн цэвдэг тархах үндсэн нөхцөлийг бүрдүүлнэ. Монгол орны цэвдгийн онцлогийг дараах байдлаар тодорхойлж болно. Үүнд:

- Тархалт нь алаг цоог байдалтай оршдог.
- Температур нь өндөр буюу 0°C ойрхон, уян.
- Дэлхийн бөмбөрцгийн хойд хагаст тархсан цэвдгийн өмнөд хил болж байдаг.
- Ул хөрс, чулуулаг улирлаар гүн хөлдөж гэсдэг.


Эдгээр онцлогоос болоод манай орны цэвдэг нь уур амьсгалын өөрчлөлт болон хүний үйл ажиллагаанд амархан өртөж, гэсэж алга болох боломжтой байдаг.




Монгол орны цэвдэг нь ихэвчлэн өндөр уулс, ой бүхий газар оршино. Монгол орны томоохон голуудын эх цэвдэгтэй газар нутгаас эх авч урсдаг.

Цэвдгийн тархалтын ирээдүйн таамаглал

2016 оны байдлаар цэвдгийн тархалтын боломжит талбайн хэмжээ 29.3%-тай байсан бол дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр 2050, 2090 онуудад энэ тоо 21.5, 16.2 хувийг тус тус эзлэхээр загварчлагдсан.



Ийнхүү ирэх 30 жил болон 70 жилийн таамаглалаар цэвдэгт хөрсний тархалт 30-50 шахам хувиар буурахаар байгаа нь тэдгээр бүсэд байгуулагдсан хот суурин газруудын цэвдэг хайлж, барилга байгууламжид нь ан цав үүсэх, эвдрэл гэмтэл гарахад сөргөөр нөлөөлөхөөр байна. Иймд тэдгээр хот суурин газруудад зам, барилга байгууламжуудыг шинээр барих болон засвар хийхдээ цэвдгийн хайлалтад зохицсон технологийг нэвтрүүлэх нь зүйтэй юм.



Цэвдгийн хүн амын суурьшил, хот байгуулалт болон нийгэм-эдийн засагт үзүүлэх нөлөө


Цэвдгийн нөхцөлийг дутуу эсвэл буруу тооцох нь улс орны нийгэм, эдийн засагт ихээхэн сөрөг нөлөөтэй байдаг. Тухайлбал:

- . Худаг ус хөлдөх
- . Барилга байшин цуурах
- . Авто замд суулт, овойлт өгөх
- . Оршин суугчдын ая тухтай амьрах нөхцөлийг алдагдуулах.




- **Хүн малын ундны ус тасрах.**
- **Эдийн засгийн хохирол амсах.**
- **Эдийн засгийн хохирол амсах.**
- **Нийгэм, эдийн засгийн хохирол амсах.**

Зураг. Монгол орны цэвдгийн тархалт ба сумуудын төвийн байршил.



Монгол Улсын хувьд 2016 оны байдлаар нийт 105 сумын төв, хот суурин газрууд нь **цэвдэг тархах** боломжит нутаг дэвсгэрт оршиж байна.

Зураг. Сумын төвүүдийн тоо (цэвдгийн тархалтын бүс, бүслүүрээр)



Цэвдэг судлалын салбарын мониторингийн хэмжилт, хээрийн судалгааны ажлын үр дүнгээс харахад дараах сумын төвүүд цэвдэг дээр байрлаж байна. Үүнд:

- Хөвсгөл аймгийн Цагааннуур, Ренчинлхүмбэ, Улаан-Уул, Ханх, Хатгал, Арбулаг, Цагаан-Уул, Цагаан-Үүр, Цэцэрлэг, Түнэл, Цагаан-Үүр, Жаргалант, Баянзүрх
- Завхан аймгийн Тосонцэнгэл, Тэлмэн, Нөмрөг, Отгон, Түдэвтэй, Цэцэн-Уул, Яруу
- Архангай аймгийн Цахир, Тариат, Хангай, Өндөр-Улаан
- Баянхонгор аймгийн Баянбулаг, Гурванбулаг, Заг, Жаргалант, Галуут
- Өвөрхангай аймгийн Уянга
- Баян-Өлгий аймгийн Цагааннуур тосгон
- Төв аймгийн Мөнгөнморьт зэрэг нийт 7-н аймгийн 31 орчим сумын төвүүд байна.

Тодруулбал Хөвсгөл аймгийн 4 сум (Цагааннуур, Ренчинлхүмбэ, Ханх, Улаан-Уул), Завхан аймгийн 3 сумын (Отгон, Тэлмэн, Түдэвтэй), Баянхонгор аймгийн 1 сумын (Гурванбулаг) төв үргэлжилсэн цэвдэгтэй бүсэд оршино. Баянхонгор аймгийн төв болон тус аймгийн Галуут, Ховд аймгийн Алтай, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Говь-Алтай аймгийн Эрдэнэ, Завхан аймгийн Сонгино, Увс аймгийн Хяргас зэрэг сумын төвийг цэвдгийн хүндрэлтэй нөхцөлөөс болж нүүлгэж байсан.



Зураг. Увс аймгийн Хяргас сумын хуучин төвийн буйр.

Хамгийн сүүлийн үеийн жишээ гэвэл Ховд аймгийн Алтай сумын хуучин төвийн ихэнх инженерийн барилга байгууламжид цэвдгийн сөрөг нөлөөнөөс улбаатай суулт, хагарал, гажилт ихээр илэрч тэдгээрийг ашиглах боломжгүй болсны улмаас 2009 онд тус сумын төвийг цэвдэггүй газар нүүлгэн шилжүүлсэн байдаг.

Зураг. Ховд аймгийн Алтай сумын хуучин төвийн хүүхдийн цэцэрлэгийн барилгын хананд үүссэн хагарал, цууралт.






Зураг. Баян-Өлгий аймгийн Цагааннуур тосгоны барилгын хананд үүссэн хагарал, цуурлт 2009 он.

Монгол орны хэмжээнд тавигдсан хатуу хучилттай замын 1200 орчим километр нь цэвдэгтэй бүсүүдийг дайран өнгөрч байгаа бөгөөд цэвдгийн сөрөг нөлөөнөөс болж тус замуудын зарим хэсэг дээр овойлт, суулт, хагарал, халианд автах зэрэг үзэгдэл олноор тэмдэглэгдсэн. Тодруулбал Архангай аймгийн Чулуут голын хөндий, Тэрхийн-цагаан нуурын хотос, Мөрөнгөөс Хатгал орох орчмын хатуу хучилттай замуудын зарим нэг газар суулт, овойлт өгч замын бүрэн бүтэн байдлыг эдвсэн нь тухайн чиглэлд зорчигсад болон суурьшигч иргэдийн ая тухтай амьдрах орчинд сөргөөр нөлөөлж байна.

Зураг. Монгол орны цэвдгийн тархалт ба хатуу хучилттай замын сүлжээ.



Дүгнэлт

1. Цэвдэгтэй ихэнх сумын төвүүдийн инженерийн хийц бүхий барилга байгууламжид ямар нэгэн хэмжээгээр цэвдгийн сөрөг нөлөө илэрч, заримыг нь ашиглах боломжгүй болжээ.
2. Цэвдгийн сөрөг нөлөөнөөс улбаатай деформацид орсон барилга байгууламж болон цэвдгийн төвөгтэй нөхцөлд хийхээр төлөвлөж буй барилга, байгууламжид сөрөг нөлөөнөөс хамгаалах технологи боловсруулах, ашиглах шаардлагатайг харуулж байна.

3. Манай орны нэр бүхий 31 сум, тосгоны төв цэвдэг дээр оршиж байгаа ба тус цэвдэгтэй сумуудад хүйтэн болон дулаан цэвдгийн төрлүүд хоёулаа илэрсэн. Энэ нь цаашид цэвдгийн сөрөг нөлөөнөөс улбаатай деформациад орсон барилга байгууламжийн тоо өснө гэдгийг харуулна.
4. Хот, суурин төлөвлөлт, инженерийн хийц бүхий барилга байгууламж барихаасаа өмнө инженерийн цэвдгийн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж байх шаардлагатай болж байна.
5. Дээр өгүүлсэн баримтуудаар цэвдгийн сөрөг нөлөө манай улсын нийгэм, эдийн засагт багагүй хохирол үзүүлж буй нь илт байна.

3.5.2 Газар хөдлөлт ба хүн амын суурьшил


Манай орны нийт нутаг дэвсгэрийн 55.4 хувь нь газар хөдлөлийн 7-8 баллын ангилалд, 9 ба түүнээс дээш баллын ангилалд 19.6 хувь нь хамрагдаж байна.

Сүүлийн 50 гаруй жилийн хугацаанд Монгол Улсын нутаг дэвсгэрт хийгдсэн газар хөдлөлтийн судалгаагаар манай улсын нийт хот, суурин газрын 75 орчим хувь нь газар хөдлөлтийн 7 ба түүнээс дээш, 12 сум, суурин газар нь газар хөдлөлтийн 9 ба түүнээс дээш баллын газар хөдлөлийн чичирхийллийн бүс нутагт оршиж байна. Эдгээр хот сууринд нийт хүн амын 85 гаруй хувь нь амьдарч байна.

Улаанбаатар хот орчимд байнгын ажиллагаатай 30 станц болон нүүдлийн зургаан станцыг ажиллуулж газар хөдлөлтийн идэвхжилтийг тасралтгүй байдлаар хянадаг байна. 2013 он гарсаар зургаан сарын байдлаар нийтдээ 925 газар хөдлөлт болсноос 95 хувь буюу 878 нь Эмээлт орчмын хагарлын дагуу болсон бөгөөд хүчний хувьд сул магнитуд нь 1,0 бага хүчтэй газар хөдлөлт, 97 хувь нь хүчтэй таван удаа болжээ. Мөн Төв аймгийн Мөнгөнморьт сумаас баруун тийш 20-30 км зайд магнитуд нь 3,8 хүрсэн. 2005 оноос хойш ажиглагдаж эхэлсэн газар хөдлөлтийн өндөр идэвхжилт өнөөг хүртэл буурахгүй жил ирэх тусам өссөөр байгаа гэсэн мэдээллийг Одон орон, геофизик судалгааны төвийн секторын эрхлэгч М.Өлзийбат мэдээлсэн.


Монгол орны газар хөдлөлтийн төлөв байдал буюу ерөнхий сейсмшилээс харахад газар хөдлөлтийн төвийн тархалт нь голчлон Монгол Алтайн нуруу, Говь-Алтайн нуруу, Булнай, Могод, Үүрэг нуур, Бүсийн гол зэрэг газар хөдлөлтийн голомтот бүс нутгуудаар болж байгаа нь ажиглагдаж байна /Зураг 26/. Энэ нь эдгээр бүс нутгуудад урьд өмнө нь болж байсан хүчтэй газар хөдлөлтүүдтэй холбоотой.

Зураг 26. Газар хөдлөлтийн ($ML > 3.5$) төвийн тархалтын зураг (1900-2015)



Газар хөдлөлтийн тоо ($M_L > 3.5$) болон жилийн хамаарлын графикаас харахад зарим онуудад газар хөдлөлтийн тоо өссөн нь ажиглагдаж байна. Энэ нь тухайн жилд идэвхжил өндөр байсан бүс нутгуудтай хамааралтай байна.

Зураг. 1964 – 2015 оны хооронд болсон газар хөдлөлтийн ($M_L > 3.5$) тоо жил тус бүрээр



3.6. Нийгэм эдийн засгийн судалгаа

Хүн амын нутагшилт бүс нутгийн судалгаанд холбогдох нийгэм эдийн засгийн бүлэгт одоогийн байдлын судалгааг улс орны, бүсийн нутгийн, аймаг, сумд, баг, хорооны түвшинд анхдагч болон хоёрдогч датаг сүүлийн 5-10 жилээр эхний ээлжинд дараах дэд ангиллаар мэдээллийн сан үүсгэхээр боловсруулалтын бэлтгэл ажил хийж байна. Үүнд:


1. Хүн амын нийгмийн үзүүлэлт
 - 1.1 Хүн амын тоо /хот, хөдөөгөөр, насны бүлэг, хүйсээр/
 - 1.2 Ажилгүйдэл
 - 1.3 Ядуурал
2. Дотоодын нийт бүтээгдэхүүн ба эдийн засгийн бүтэц
 - 2.1 ДНБ-ны жилийн цэвэр өсөлт, бууралт
 - 2.2 ДНБ-ны салбарын бүтцээр
3. Хөдөө аж ахуйн салбар
 - 3.1 Малын тоо / төрлөөр /
 - 3.2 Газар тариалан / тариалсан талбай, хураасан ургац, төрлөөр /
4. Аж үйлдвэр
 - 4.1 Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлвэрлэл /бүх төрлийн үйл ажиллагааны салбараар, эзлэх хувиар/
 - 4.2 Жижиг дунд үйлвэрлэл / салбараар, эзлэх хувиар /
5. Хөрөнгө оруулалт
6. Нийгмийн дэд бүтцийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаархи судалгаа

Нийгэм эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг хүснэгтийн дагуу сүүлийн 5-10 жилийн тоон мэдээлэл цуглуулахаар бэлдээд байна.

3.6.1. Хотууд болон орон нутгийн эдийн засаг

Дэлхийн эдийн засагт хотуудын эзлэх байр суурь өндөр байдгийн адилаар эрчимтэй хотжилт явагдаж буй Монгол Улсын эдийн засагт томоохон хот суурины эзлэх хувь өндөр байгаа бөгөөд жилээс жилд нэмэгдэж байна. Тухайлбал зөвхөн Улаанбаатар хот, Орхон аймгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ Монгол улсын ДНБ-ний 70 гаруй хувийг эзэлдэг.

Зураг. Аймгуудын ДНБ-д эзлэх хувь




Энэхүү том хотуудыг чиглэсэн нийгэм эдийн засгийн таталцлын нөлөөгөөр үйлдвэрлэл, үйлчилгээ нь цөөн тооны томоохон хот сууринд хэт төвлөрч, бусад аймгуудын эдийн засаг биеэ даан хөгжихөд сөргөөр нөлөөлж байна. Өнөөгийн байдлаар Улаанбаатар хот, Орхон, Дорноговь, Өмнөговь аймгууд дотоодын төсвийн орлогоор зарлагаа нөхөх бололцоотой, бусад аймгууд улсын төсвөөс татаас авч зарлагаа нөхөж байна.

Зураг 1. Аймгуудад өгч буй улсын төсвийн санхүүгийн дэмжлэг



Хэдийгээр улсын төсвөөс татаас авдаг аймгуудын тоо буурахгүй байгаа ч нийт татаасын бодит дүн жилд 7 орчим хувиар буурч байна.


Зураг 2. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгосон санхүүгийн дэмжлэг



Улсын дунджаар орон нутгийн төсвийн орлогын 40 орчим хувийг урсгал орлого, үлдэх хэсгийг тусламжийн орлогоор бүрдүүлж байна. Орон нутгийн төсвийн урсгал зардлыг санхүүжүүлэхэд нэгдсэн төсвөөс татаас өгдөг ба энэ нь орон нутгийн төсвийн 8 орчим хувь байдаг. Орон нутгийн төсөвт Улсын гэрээгээр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны төсөв буюу Төсвийн ерөнхийлөн захирагчдын улсын төсвөөс орон нутагт зарцуулж байгаа зардал хамгийн их 42 орчим хувийг эзэлдэг. Энэхүү зардал нь эмнэлэг, сургууль, орон сууц ашиглалт, засварын зардлаас голчлон бүрдэнэ. 2003 онд батлагдсан “Төсвийн


байгууллагын удирдлага санхүүжилтын тухай хууль”-ийн дагуу төсвийн байгууллагуудын урсгал зардлыг орон нутгаас шилжүүлэн Төсвийн ерөнхийлөн захирагчдын мэдэлд шилжүүлсэнээр “доороос дээш чиглэсэн” төсөв боловсруулж, баталдаг байсан хуучин тогтолцоонд томоохон өөрчлөлт орсон. Үүний үр дүнд 2003 оноос хойш Төсвийн ерөнхийлөн захирагчдын улсын төсвөөс орон нутагт зарцуулж байгаа зардал 30 хувиар нэмэгдэж, орон нутгийн төсвийн хэмжээ хумигдсан.

Зураг. Нэг хүнд жилд ногдох ДНБ-ий хэмжээ, 2017 он, мянган төгрөгөөр



Аймгуудын нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээг харьцуулж үзвэл баруун бүсийн хамгийн хол алслагдсан аймгууд болох Баян-Өлгий, Увс, Ховдод 3,3-4,0 сая төгрөг байхад Орхон, Улаанбаатар хот, Өмнөговь аймагт баруун бүсийн аймгуудаас 3-4 дахин өндөр байгаа нь хүн амын шилжилт хөдөлгөөнд ч бас давхар нөлөөлж байна.

Зураг. ДНБ-д эдийн бүсүүдийнн эзлэх хувийн өөрчлөлт, 2000-2017 онд




Зураг. Орон нутгийн төсвийн бүтэц



Орон нутгийн төсвийн үлдэх 10 орчим хувийг “Орон нутгийн хөгжлийн сан” бүрдүүлдэг. Монгол Улс 2011 онд төсвийн тухай хуулийг шинэчлэн баталсан ба энэ хуулиар орон нутгийн төсвийн эрх мэдлийг өсгөх, орон нутгийн албан тушаалтнуудын идэвхи санаачилга, хариуцлагыг сайжруулах, төсвийн зарцуулалтад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн хөгжлийн санг байгуулсан.

Зураг3. Орон нутгийн төсвийн орлогын бүрдэл



Уг сангийн хөрөнгийг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар 2017 онд 350 орчим тэрбум төгрөг төвлөрүүлсэн. Сангийн эх үүсвэрийг цаашид тогтмол хангах зорилгоор импортоос бусад бараа, ажил, үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын 25 хувь, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 5 хувь, орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив, орон нутгийн төсвийн зардлаас давсан орлогыг санд төвлөрүүлэхээр тогтоосон. Улсын төсвөөс орон нутгийн хөгжлийн санд хөрөнгө хуваарилах хязгаарыг тодорхойлохдоо орон нутгийн хөгжлийн индексийг ашигладаг. Уг индекс нь хүн ам, нутаг дэвсгэрийн хэмжээ, алслалт, орон нутгийн татварын идэвх санаачилга гэсэн үзүүлэлтүүдийг ижил хувь хэмжээгээр тооцож байна.

Орон нутгийн төсвийн томоохон бүрдэл хэсэг татварын орлого нь улсын дунджаар 35 орчим хувьтай байна. Монгол Улс 2008 онд “Татварын ерөнхий хууль”-ийг шинэчлэн баталсан. Уг хуульд аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хувь хэмжээг нь тогтоож орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, тухайн нутаг дэвсгэрт үйлчлэх татварын төрлүүдийг тогтоосон.

Зураг. Орон нутгийн татварын орлогын ангилал

Аймаг, нийслэлийн төсвийн татварын орлого

- Нийслэл хотын албан татвар
- Газрын төлбөр
- Үл хөдлөх хөрөнгийн татвар
- Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татвар
- Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр
- Цалин хөлс, түүнтэй адилтгах хувь хүний орлогын татвар
- Өв залгамжлал, бэлэглэлийн татвар
- Улсын тэмдэгтийн хураамж

Сум, дүүргийн төсвийн татварын орлого

- Хувь хүний албан татвар
- Бууны албан татвар
- Улсын тэмдэгтийн хураамж
- Агнуурын нөөц, ан амьтан барих зөвшөөрлийн хураамж
- Байгалийн ургамал ашигласны төлбөр
- Ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласны төлбөр
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр
- Хүн амын үнд, ахуйн зориулалтаар ус, рашаан ашигласны төлбөр
- Хувь хүний орлогын албан татвар
- Нохойны албан татвар

Орон нутгийн хүн амын төвлөрөл, нөөцийн харилцан адилгүй байдлаас шалтгаалан орон нутгийн урсгал орлогын төсвийн орлогод эзлэх хувь хэмжээ ялгаатай байдаг. Тухайлбал, Нийслэл Улаанбаатар хотын төсвийн 80 гаруй хувийг урсгал орлого бүрдүүлдэг бол Өмнөговь аймаг 92, Дархан-Уул аймаг 80, Завхан аймаг 42 хувь байна.

3.6.2. Нийгмийн дэд бүтцийн үйлчилгээ

Монгол улсын хэмжээнд нийгмийн дэд бүтцийн төлөвлөлт буюу боловсрол, эмнэлэг, эрүүл мэндийн байгууллага, соёлын байгууллага, орон сууцны хангамжийн талаарх судалгааг хийж байна.

Судалгааг 1990/1991 он, 2005/2006 он, 2017/2018 оны байдлаар, мөн аймаг болон бүс нутаг тус бүрээр нь тоо хэмжээг нэгтгэж, харьцуулах байдлаар хийж байгаа болно.

Боловсролын салбарын судалгаа: Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, коллеж, их дээд сургуулиудын тоо хэмжээ болон сургалтанд хамрагсад, төгсөгчдийн тоог мөн 1990/1991 он, 2005/2006 он, 2017/2018 оны байдлаар, мөн аймаг болон бүс нутаг тус бүрээр нь судалж нэгтгэсэн.

Мөн сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын байгууллага, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, коллеж, их, дээд сургуулиудыг төрийн өмчийн болон хувийн хэвшлийн гэсэн чиглэлээр тоо хэмжээг тусд нь гаргаж байна.

Эрүүл мэндийн салбарын судалгаа: Эмнэлгийн багууллага, эмнэлгийн орны тоо, эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн хүний тоо болон 1 эмч, 1 сувилагчид ногдох хүний тоо гэсэн чиглэлээр 2000, 2010, 2018 оны байдлаар нь судалгааг гаргасан бөгөөд мөн эмнэлгийн байгууллагын тоог улсын болон хувийн гэсэн ангиллаар харьцуулан судалж байна.

Дээрх тоо хэмжээг Улаанбаатар хот болон бүс, аймаг, сумын хэмжээнд гаргаж харьцуулах судалгааг хийж байна.

Орон сууцны хангамжийн судалгаа: Монгол улсын хэмжээнд орон сууцны барилгын тоо хэмжээг бусад зориулалтын буюу орон сууцны бус барилгын тоо хэмжээтэй харьцуулах, мөн орон сууцны барилгыг талбайн хэмжээгээр нь судалгааг гаргаж байна.

Дээрх тоо хэмжээг 2000, 2010, 2018 оны байдлаар Улаанбаатар хот, бүс, аймаг, сумын хэмжээнд гаргаж, харьцуулалт хийж байгаа болно.

Мөн орон сууцны барилгад оруулсан нийт хөрөнгийн хэмжээг 2000 оноос 5 жил тутамд буюу 2005, 2010, 2015, 2018 оны байдлаар судалгааг гаргасан.

Соёл, урлагийн салбарын судалгаа: Монгол улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа номын сан, музей болон үзмэр, шашны байгууллага, сүм хийд, биеийн тамир, спортын байгууллага, соёлын төв зэргийн тоо, энэ чиглэлийн байгууллагын нийт ажилтны тоо, үйлчлүүлэгчдийн тоо гэсэн чиглэлээр судалгааг хийх ба 1995, 2010, 2018 онуудын байдлаар нийслэл, бүс, аймаг, сумын хэмжээнд судалгааг хийх юм.


Дээрх чиглэлээр гаргасан судалгааг үндэслэн нэгдсэн харьцуулалт хийх, дүгнэлт гаргах замаар тулгамдсан асуудлууд болон тэдгээрээс гарах арга зам, төлөвлөлтийн оновчтой шийдлийг өөрийн зүгээс тодорхойлох зорилготой ажиллаж байгаа болно.

3.7. Хүн амын нутагшилт суурьшлын судалгаа, дүн шинжилгээ

Монгол Улсын хүн ам 1918 онд 647.5 мянга байсан бол 2017 оны байдлаар 3177 мянгад хүрч, ХХ зуунд бараг дөрөв дахин өсчээ. Томоохон өсөлт нь 1960 ба 1970-аад онд болж, тухайн үед хүн амын жилийн дундаж өсөлтийн коэффициент 3.0 хувьд дөхөж, хүн ам 25 хүрэхгүй жилийн дотор хоёр дахин өссөн ажээ. Эдгээр жилүүдэд төрөлт ихтэй байсантай холбогдон сүүлийн жилүүдэд хөдөлмөрийн насны залуучууд олноор нэмэгдэж байна. 1990 оноос хойш улс оронд үүссэн эдийн засгийн хямралтай холбогдон хүн амын өсөлт буурсан нь үндсэндээ төрөлтийн огцом бууралтын үр дүн байлаа.

Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын үндсэн 2 хэлбэр нь хот, хөдөө бөгөөд хүн амын шилжилт хөдөлгөөний нөлөөгөөр хотжилт эрчимтэй явагдаж 2017 оны байдлаар 68,7 хувьд хүрээд байна. Тодруулбал нийт хүн амын 45 хувь нийслэлд (агломераци буюу том хот дагасан), 29 хувь нь нийт 350 хот, суурин газарт (Шугаман буюу авто замын тэнхлэг дагасан), үлдэх 26 хувь нь хөдөөд (жигд буюу засаг захиргааны нэгжүүд дагасан) амьдарч байна.

Зураг . Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцооны өнөөгийн байдал




Хүснэгт 17. Хүн амын нутагшилт, суурьшлын байдалд хийсэн SWOT дүн шинжилгээ

<p>Давуу тал</p>	<ul style="list-style-type: none"> • Хүн амын нутагшил, суурьшил, хөдөлгөөнд тавигддаг байсан засаг захиргаа, хууль эрх эдийн засгийн хориг саад багассан • Зам тээвэр, эрчим хүчний харьцангуй сайн үндсэн сүлжээ бүрэлдсэн • Эрүүл мэнд, боловсрол зэрэг нийгмийн суурь үйлчилгээний дэд бүтэц бүрэлдсэн • Хүн амын нутаг дэвсгэрээр жигд тархан суурьшсан • Хүн амзүйн цонх үе нээгдсэн • Уул уурхай, үйлдвэрлэлийн хөгжлийг дагаад суурьшлын шинэ төвүүд бий болох таатай нөхцөл бүрдсэн
<p>Сөрөг тал</p>	<p><u>Хот байгуулалтын хувьд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Хүн амын хэт төвлөрөл (1 хотод нийт хүн амын 44.0 хувь), хэт сарнил (350 гаруй хот, суурин газарт нийт хүн амын 30.0 хувь амьдардаг) - Орон нутагт хүн ам, зах зээлийн зохистой төвлөрөл бүрдээгүйгээс ажилгүйдэл, ядуурал нэмэгдсэн - Хөдөөнөөс төвийг чиглэсэн их нүүдлээс шалтгаалж, нийслэлд хүн амын хэт төвлөрөл үүссэнээр авто зам, ус, цахилгааны хангамж зэргээр дэд бүтцэд сөргөөр нөлөөлөх болсон. <p><u>Нийгмийн хувьд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Засаг захиргааны хэт олон жижиг нэгжид хуваагдсанаар цус ойртолт зэрэг хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг - Хэдий засаг захиргааны нэгж тус бүрт эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний дэд бүтэц байгаа ч чанар, хүртээмж муу учир өртөг зардал ихтэйгээр эдгээр үйлчилгээгээр төв рүү таталцдаг. - Гадаадад 120.0 мянга гаруй монгол иргэн харьцангуй бага цалин хөлстэйгээр ажиллаж, амьдарч буй бол монголд 20.0 мянга орчим гадаадын иргэн харьцангуй өндөр цалин хөлстэй ажиллаж байна. Өөрөөр хэлбэл хүн ам, хөдөлмөрийн нөөц болон эдийн засгийн гадагш чиглэсэн урсгал харьцангуй их байна. <p><u>Эдийн засгийн хувьд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Аймаг, сум жижигрэх тусам 1 хүнд ногдох эрүүл мэнд, боловсрол зэрэг төрийн үйлчилгээний өртөг зардал нэмэгдэж, эсрэгээр тэдгээрийн чанар, хүртээмж тааруу байна. - Төсвийн үрлэгэн тогтолцоо - Эдийн засгийн хувьд аймаг, сумд нь улсын төсвөөс бүрэн хараат байдалтай <p><u>Хууль, эрхзүйн орчны хувьд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Сум, орон нутгийн бие даан хөгжих, нутгийн өөрөө удирдах эрхзүйн орчин маш сул - Сум, орон нутгийн байгууллагын төсвийн эрх мэдэл бага. <p><u>Экологийн хувьд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Ажиллах хүчний дийлэнх буюу 34.0 хувийг эзлэх хөдөө аж ахуй, тэр дундаа мал аж ахуйн салбар уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг болж, энэ салбарт ажиллагсдын тогтвортой амьжиргаанд сөргөөр нөлөөлөх болсон. - Нийт сумын тал орчим хувьд улирлын бэлчээр дутмаг. - Усны хомсдол нэмэгдэж, усны сав газрын хэмжээнд олон сумд хамрагддаг нь тэдгээрийг усны нэгдсэн менемент хийхэд сул тал болдог.
<p>Аюул занал, эрсдэл</p>	<ul style="list-style-type: none"> - Нийт хүн амын 44.0 хувь оршин суух нийслэл Улаанбаатар хотод хүрээлэн буй орчны бохирдол, дэд бүтцийн ачаалал ихэссэнээс хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхээ эдлэхэд ноцтой аюулд хүргэж байна. - Оюутолгой, Тавантолгой зэрэг стратегийн томоохон ордуудыг түшиглэсэн хот байгуулалтын бодлого байхгүйгээс ажилчид тогтвор суурьшилтай ажиллах, гэр бүлийн орчноос хол амьдарч байгаагаас үүдэлтэй гэр бүл салалт зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүд гарч байна. - Үйлдвэрлэлийн хөгжил, төвлөрлийг даган сүүлийн жилүүдэд нэмэгдсээр буй

	гадаадын ажиллах хүчний өсөлт, дотоодын ажиллах хүчний эрэлт хэрэгцээний хомсдол - Орон нутгийн хөгжлийг уясан төсвийн хараат байдал
Боломж	- Хүн амд төрийн үйлчилгээг ойр хүргэх үүднээс аймаг, сум бүр дээрхи одоогийн төрийн үйлчилгээний (эрүүл мэнд, боловсрол зэрэг) дэд бүтцийг тогтвортой ашиглах шаардлагатай. - Уул уурхай, үйлдвэрлэлийн өсөлтийг даган их хөрөнгийг үр ашигтай шингээх чадавхи бүхий шинэ хотыг төлөвлөн хөгжүүлбэл нийслэлийн хүн амын хэт төвлөрлийг сааруулж чадна.


Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоо алдагдсан байна. Тухайлбал нэг хүнд ногдох газар нутгийн хэмжээгээр дэлхийд тэргүүлдэг хэрнээ нийт хүн амын нэг хотод ногдох хувиар дэлхийд тэргүүлж байна. Дэлхийн хамгийн их агаарын бохирдолтой Улаанбаатар хотод нийт улсын хүн амын 50 шахам хувь амьдарч байгаа нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд ноцтойгоор нөлөөлж байна. Иймд хотыг дахин төлөвлөж хөгжүүлэхээс өмнө Монгол Улсын болон нийслэлийн хүн амын нутагшилт, суурьшлын зохистой бодлогыг боловсруулах шаардлагатай байна. 2017-2022 онд Монгол Улсын хүн ам 3.2-с 3.5 сая болж, хотын хүн ам буюу нийслэлийн хүн ам 200-300 мянгаар нэмэгдэх төлөвтэй байна. Хэдий Оюутолгой, Тавантолгой, Сайншанд, Багануурын оюутны хотхоныг түшиглэсэн нийт 160-170 мянган хотын хүн амын төвлөрөл бий болохоор төлөвлөж буй хэдий ч тэдгээрт хүн амын суурьшлын шинэ төв бий болгох талаархи алхмууд удаашралтай байна.

Зураг 10. Монгол Улсын болон дэлхийн хотжилтын түвшин



Эх сурвалж: UN, Population Division, World population prospects 2017


Зураг 11. Хотын хүн амын нийт хүн амд эзлэх хувиар дэлхийн улсуудтай харьцуулалт, 2016



Эх сурвалж: UN, Population Division, World population prospects 2017


Монгол Улсад 1990 оноос хойш хотжилтын түвшин хурдацтай нэмэгдэж, 68,6 хувь буюу Итали, Унгар зэрэг өндөр хөгжилтэй орнуудын түвшинд хүрсэн байна. Иймд бусад өндөр хөгжилтэй орнуудын жишгийн дагуу хотуудад, ялангуяа нийслэл хотод хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг хангах шаардлагатай. 1990-2017 онд Монгол Улсын хүн ам 2.0 саяас 3,2 сая болж, 55 хувиар, тэр дундаа хотын хүн ам 1.0 саяас 2.3 сая болж 2.3 дахин, нийслэлийн хүн ам 0.5 саяас 1.3 сая болж, 2.6 дахин ихээр өссөн байна. Үндсэндээ дээрх хугацаанд өссөн хүн ам нь нийслэлийн хүн ам болж байна.

Хүн ам ихээр шилжин ирж байгаагаас Улаанбаатар хотын дэд бүтэц, нийгэм, төрийн үйлчилгээний ачаалал даац нэмэгдэж, хотын тогтвортой хөгжилд сөргөөр нөлөөлөх боллоо. Сүүлийн 20 жилд шилжин ирэгсдийн тоог аймгуудын хүн амтай харьцуулбал нийт 8 аймгийн хүн амын тоотой дүйцэхүйц 452 мянган хүн орон нутгаас Улаанбаатар хотод шилжин иржээ. Улмаар Монгол Улсын хотжилтын түвшин дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын жишигт хүрсэн.



Зураг 12. Монгол Улсын хүн амын өсөлт, байршлаар

Өнгөрсөн зууны турш хүн амын тооны динамикаас харахад хөдөөгийн хүн амын тоо тогтвортой байгаа нь хөдөөд нүүдлийн бэлчээрийн мал аж ахуйг эрхлэх хүн ам бэлчээрийн даацаас хамаараад харьцангуй тогтвортой байж ирснийг харуулж байна (Зураг 3). Харин хүн амын өсөлт нь үндсэндээ хотын хүн амын өсөлт байх хандлагатай байна. Аймгийн төв хотуудын хувьд төмөр замын тэнхлэг дагасан Эрдэнэт, Дархан, Сайншанд, Замын-Үүд, Чойр болон автозамын гол тэнхлэгүүдийг даган байршсан, автозамын гол тэнхлэгийн дагуух Налайх, Багануур, Баянхонгор, Арвайхээр хотуудын хүн ам өссөн тэнхлэгийн дагуух хот суурин газруудад нийгэм-эдийн засгийн таталцал явагдаж байгааг харуулж байна. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийхэд давуу талаасаа сул тал нь илүү ихээр давамгайлсан байгаа өөрчлөлтийг хийх шаардлага нэгэнт тулгараад байгааг харуулж байна. Монгол Улс 1990-ээд оноос зах зээлийн харилцаанд шилжсэнээр хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцоонд нэлээд өөрчлөлт оржээ.



Зураг. Хүн амын тоо, суурьшлын хэлбэрээр, 1956-2017 онд


Хүснэгт 18. Хүн амын шилжих хөдөлгөөнд татаж буй болон түлхэж буй хүчин зүйлс

<p>ТАТАХ ХҮЧИН ЗҮЙЛС</p> <p>Хөдөө орон нутгийн иргэдийг УБ хот болон Төвийн бүс рүү шилжин ирэх хөдөлгөөнд татаж буй</p>	<p>Нийгэм:</p> <ol style="list-style-type: none"> 1. Гэр бүл, хамаатан садны хэлхээ холбоотой 2. Гэр бүл болох сонголт их 3. Боловсрол, эрүүл мэндийн сайн үйлчилгээнд татагдах <p>Эдийн засаг:</p> <ol style="list-style-type: none"> 1. Үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэхэд зах зээл том 2. Өргөн хэрэглээний барааны үнэ харьцангуй хямд 3. Хүн амын худалдан авах чадвар өндөр 4. Ажлын байр олох магадлал өндөр 5. Өндөр цалинтай ажил олох бололцоотой 6. ХАА-н бүтээгдэхүүний хэрэглэгчдийн зах зээлд ойр <p>Хүрээлэн буй орчин:</p> <ol style="list-style-type: none"> 1. Зарим бүс нутгаас харьцангуй дулаан 2. Ойт хээр, хээрийн бүс нь зарим бүсээс газрын үржил шим илүү 	<p>ТҮЛХЭХ ХҮЧИН ЗҮЙЛС</p> <p>Хөдөө орон нутгаас хүн амыг нийслэл рүү шилжин явах хөдөлгөөнд түлхэж буй</p>	<p>Нийгэм:</p> <ol style="list-style-type: none"> 1. Ажилгүйдэл 2. Ядуурал 3. Боловсрол, эрүүл мэнд зэрэг төрийн үйлчилгээний чанар хүртээмж сул 4. Ялгаварлан гадуурхах үзэл илүү 5. Гэр бүл болох сонголт бага <p>Эдийн засаг:</p> <ol style="list-style-type: none"> 1. Зах зээл бага 2. Ажлын байрны хомсдол 3. Хүнсний болон хувцас зэрэг өргөн хэрэглээний барааны үнэ харьцангуй өндөр 4. Дэд бүтэц сул 5. Хүн амын худалдан авах чадвар сул <p>Хүрээлэн буй орчин:</p> <ol style="list-style-type: none"> 1. Уур амьсгалын өөрчлөлт 2. Ган, зуд, үеийн байгалийн гамшиг 3. Усны доройтол 4. Орчны бохирдол
---	--	---	---


Нийслэлийн хүн амын хэт төвлөрлийг сааруулахын тулд бүсүүдэд болон нийслэлийн дагуул хотуудыг нийслэлтэй өрсөлдөх чадвар бүхий татах хүчин зүйлстэй болгож хөгжүүлэх шаардлагатай юм.

Хүн амын өөрчлөлтийг нутагшилт, суурьшлаар нь аймгийн төв буюу хот, сумын төв, хөдөө нутгаар дараахь зурагт харууллаа.


Зураг 13. Аймгийн төв, сумын төв болон сумдын хүн амын тооны өөрчлөлт



Улаанбаатар хотыг оруулаад нийт 22 аймгийн төв буюу улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, суурин газраас 4 хотын хүн ам буурсан, 10 хотын хүн амын хэвийн өсөлттэй, 8 хотын хүн ам механик өсөлттэй байна.




Харин сумын төв, суурин газраас 166 сумын төвийн хүн буурсан, 59 сумын төвийн хүн ам хэвийн өссөн, 92 сумын төвийн хүм механик өсөлттэй байна. Сумын түвшинд зөвхөн хөдөө нутагт нүүдэллэн амьдарч буй хөдөөгийн хүн амын өөрчлөлтөөр 215 сумын хөдөөгийн хүн ам буурчээ.



Хүснэгт 19. Хүн амын тоо нь хамгийн ихээр өссөн хот, сум, суурин газрууд, 2005-2017 онд

№	Хот, сум	2005	2017	Жилийн өсөлт %	Үүрэг
1	Цогтцэций	2128	7262	20.1	Уул уурхай
2	Ханбогд	2618	6682	12.9	Уул уурхай
3	Замын-Үүд	8058	17880	10.2	Гадаад худалдаа
4	Даланзадгад хот	15810	24467	4.6	Уул уурхай
5	Баруун-Урт хот	13616	20713	4.3	Засаг захиргаа
6	Улаанбаатар хот	933971	1399094	4.2	Засаг захиргаа, эдийн засаг
7	Налайх хот	26112	36668	3.4	Дагуул хот
8	Чойр хот	8971	12531	3.3	Засаг захиргаа
9	Гурвантэс	3457	4799	3.2	Уул уурхай
12	Өндөрхаан хот	16849	22465	2.8	Засаг захиргаа
13	Сайншанд хот	18473	24415	2.7	Тээврийн зангилаа, уул уурхай
14	Арвайхээр хот	23566	31090	2.7	Засаг захиргаа, тээврийн зангилаа
16	Алтанбулаг	3913	5070	2.5	Гадаад худалдаа


Сүүлийн 12 жилийн хугацаанд хүн амын тоо хамгийн ихээр өссөн хот, суурин газруудад уул уурхай дагасан Өмнөговь аймгийн Гурвантэс, Цогтцэций, Ханбогд сум, Даланзадгад хот, гадаад худалдаа хилийн боомт дагасан Замын-Үүд сум болон засаг захиргааны төв болсон Улаанбаатар, Баруун-Урт хот орж байна.



Монгол Улсын нийт хөдөөгийн сумдын хүн амын тооны ангиллаар 2017 оны байдлаар авч үзвэл нийт сумдын 53 хувь нь 3000 хүртэл хүнтэй, 86 хувь нь 5000 хүртэл хүнтэй бол

ердөө 14 хувь нь 5000-аас дээш хүнтэй байна. Хүн амын тоог нутагшилт, суурьшлийн хувьд аймгийн төв буюу хот, сум суурин газраар 1996, 2006, 2017 оны орон зайн өөрчлөлтийг харууллаа.

Зураг 16. Хот, сум, суурин газруудын хүн амын тооны өөрчлөлт, 1996-2013 онд



Хүн амын тоог нутагшилт, суурьшлийн хувьд аймгийн төв буюу хот, сум суурин газраар 1996, 2006, 2017 оны орон зайн өөрчлөлтөөс харахад сумдын хүн амын тоо илүү ихээр буурсан нь тодорхой харагдаж байна.

Хүснэгт 20. Монгол Улсын хилийн боомт оршдог сумдын хүн амын тооны өөрчлөлт

№	Аймаг, сум	Боомт	Зэрэглэл	Хүн амын тоо		Хүн амын жилийн дундаж өсөлт, хувиар			
				1990	2017	1990-2000	2000-2010	2010-2017	1990-2017
1. БНХАУ-тай хиллэдэг боомтууд									
1.1	Дорнод, Халхгол	Сүмбэр-Рашаан	2 талын түр	1858	3047	9.8	-1.1	-1.0	2.4
1.2	Дорнод, Халхгол	Баянхошуу-Өвдөг	2 талын, байнгын	1858	3047	9.8	-1.1	-1.0	2.4
1.3	Дорнод, Чойбалсан	Хавирга-Ар Хашаат	2 талын, байнгын	2845	2725	0.6	-1.1	0.2	-0.2
1.4	Сүхбаатар, Эрдэнэцагаан	Бичигт-Зүүнхатавч	олон улсын, байнгын	4826	6677	2.1	1.1	0.4	1.4
1.5	Дорноговь, Замын-Үүд	Замын-Үүд-Эрээн	олон улсын, байнгын	1332	18241	36.0	12.5	4.6	47.0
1.6	Дорноговь, Хатанбулаг	Ханги-Мандал	2 талын, байнгын	2761	2919	1.5	-0.2	-0.8	0.2
1.7	Өмнөговь, Ханбогд	Гашуунсухайт-Ганцмод	2 талын, байнгын	1929	6978	2.0	5.3	14.0	9.7
1.8	Өмнөговь, Гурвантэс	Шивээхүрэн-Сэхээ	2 талын, байнгын	2652	4869	2.3	3.1	2.1	3.1
1.9	Говь-Алтай, Алтай	Бургастай-Ласемяо	2 талын түр	2000	2063	2.7	-1.8	-0.1	0.1
1.10	Ховд, Булган	Байтаг-Улиастай	2 талын түр	8545	10126	1.0	-0.1	1.3	0.7
1.11	Ховд, Булган	Булган-Такашикен	олон улсын, байнгын	8545	10126	1.0	-0.1	1.3	0.7
1.12	Баян-Өлгий, Сагсай	Даян-Хуншанзюй	2 талын, түр	4765	5259	0.2	-0.3	1.6	0.4
2. ОХУ-тай хиллэдэг боомтууд									
2.1	Баян-Өлгий, Ногооннуур	Цагааннуур-Ташанта	олон улсын, байнгын		7976	-4.1	0.4	1.1	0.7
2.2	Увс, Тэс	Тэс-Шарсуурь	2 талын, даваа-бямба	7679	5273	-1.1	-2.4	0.2	-1.2
2.3	Увс, Давст	Боршоо-Хандгайт	2 талын, байнгын	2298	1703	-1.7	-1.0	-0.3	-1.0
2.4	Завхан, Тэс	Арцсуурь-Цагаантолгой	2 талын, даваа-бямба	3055	2937	0.1	0.0	-0.7	-0.1
2.5	Хөвсгөл, Ханх	Ханх-Монд	2 талын, даваа-баасан	1192	2783	8.5	1.3	1.7	4.9
2.6	Сэлэнгэ, Алтанбулаг	Алтанбулаг-Хиагт	олон улсын, байнгын	3714	5089	-0.5	4.4	0.1	1.4
2.7	Сэлэнгэ, Сүхбаатар	Сүхбаатар-Наушки	олон улсын, байнгын	25346	22911	-1.9	0.8	0.5	-0.4
2.8	Дорнод, Баян-Уул	Ульхан-Дээд Ульхан	2 талын, даваа-баасан	3988	4654	2.9	-1.4	0.8	0.6



2.9	Дорнод, Чулуунхороот	Эрээнцав- Соловьевск	олон улсын, байнгын	2338	1785	-3.1	0.2	1.3	-0.9
-----	-------------------------	-------------------------	------------------------	------	------	------	-----	-----	------

Сүүлийн жилүүдэд ОХУ-тай харилцан визгүй горимоор зорчих болсонтой холбоотойгоор зорчигч тээврийн урсгал нэмэгдсэн болон БНХАУ-тай хил залгаа боомтуудаар уул уурхайн бүтээгдэхүүний экспорт ихээр нэмэгдсэнтэй холбоотойгоор хилийн боомтууд дагасан сумдын хүн амын тоо өсч байна.

Засаг захиргааны нэгжүүдээр хүн амын тоо ихээхэн ялгаатайгаас болж төрийн үйлчилгээний чанар, хүртээмж ихээхэн ялгаатай байна.


Тухайлбал Улаанбаатар хотын дүүргүүдийн хүн амын тоо өөр хоорондоо 82 дахин их, хороодын хүн амын тоо 35 дахин их, аймгийн хүн амын тоо 8 дахин их, багийн хүн амын тоо 50 дахин ихээр хоорондоо зөрүүтэй байна. Түүнчлэн засаг захиргааны нэгжүүд, хот суурин газруудын ангиллын тодорхой шалгуур үзүүлэлтүүд байхгүйгээс болж хүн амын тоогоор сумаас том баг, аймгаас том сум, дүүргээс том хороо, хотоос тосгон байсаар байна. Үүнээс хамаарч боловсрол, эрүүл мэнд, төрийн захиргааны үйлчилгээний чанар хүртээмж сул байна. Учир нь хэт цөөн хүнтэй засаг захиргааны нэгжид чадавхитай боловсон хүчин дутагдалтай байгаагаас болж үйлчилгээний чанар муу байгаа бол хүн амын тоо хэт их нэгжид төрийн үйлчилгээний хүртээмж сул байна.






Баянзүрх дүүргийн хүн 336 мянгад хүрснээр Багахангай дүүргээс 82 дахин их хүнтэй болсон нь төрийн албан хаагчдын төрийн үйлчилгээний ачааллыг эрс нэмэгдүүлж байна.

Зураг 20. Улаанбаатар хотын дүүргүүдийн 1 хороонд ногдох хүн амын дундаж тоо, 2017 он




Зураг 21. Улаанбаатар хотын хамгийн олон болон цөөн хүн амтай 10 хороодын хүн амын тоо, 2017 он




3.7.1. Хүн амын хөдөлмөрийн зах зээлийн судалгаа

Хүн ам, хөдөлмөрийн зах зээлийн судалгааг дараах үзүүлэлтүүдээр цуглуулан мэдээллийн сан үүсгэж, боловсруулалт хийж байна.

1. Ажил хайгч иргэд болон бүртгэлтэй ажилгүй иргэд
 - Аймаг, дүүргүүдийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдэд ажил идэвхтэй хайж буй ажил хайгч иргэдийн тоо. Ажил хайгч иргэдийн иргэний харьяалалаар.
 - Ажил хайгч иргэдийн насны бүлэг, хүйс
 - Ажил хайгч иргэд, боловсролын түвшнээр
 - Бүртгэлтэй ажилгүй иргэд, иргэний харьяалалаар
 - Бүртгэлтэй ажилгүй иргэд бүсээр, хүйсээр, боловсролын түвшнээр
2. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ
 - Ажил олгогч иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн ажлын байрны захиалга
 - Ажилд зуучлагдан орсон иргэдийн тоо, насны бүлэг, ажил мэргэжлийн ангилалаар, өмчийн хэлбэрээр
3. Ажлын шинэ байрны талаарх мэдээлэл
 - Шинээр бий болсон ажлын байр байршлаар
 - Ажлын шинэ байранд ажилд орсон иргэдийн хүйс
4. Монгол Улсын засгийн газраас авч хэрэгжүүлж буй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрүүд
 - Ажлын байрыг дэмжих хөтөлбөр
 - Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр
 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
 - Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
 - Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр
 - Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр
5. Гадаадаас ажиллах хүч авах
 - Хөдөлмөр эрхлэж буй гадаадын иргэд, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар
 - Хөдөлмөр эрхлэж буй гадаад иргэд байршлаар /ажиллаж буй аймаг, дүүрэг/
 - Хөдөлмөр эрхлэж буй гадаадын иргэд, хүйсээр, улсаар.
6. Гадаадад ажиллах хүч илгээх
 - Шалгалтын бүртгэл, хамрагдсан, тэнцсэн иргэдийн тоо
 - Ажлын байрны санал
 - БНСУ-д Хөдөлмөрийн гэрээгээр илгээсэн иргэдийн тоо



Нийт ажил хайгч иргэдийн 6949 буюу 18,7 хувь нь Баруун бүсэд, 7472 буюу 20,1 хувь нь Хангайн бүсэд 7165 буюу 19,3 хувь нь Төвийн бүсэд, 3684 буюу 9,9 хувь нь Зүүн бүсэд, 11804 буюу 31,8 хувь нь Улаанбаатарт байна.




Зураг 2. Ажил хайгч иргэн, бүсээр, хүйсээр, 2017 он

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагуудын үйл ажиллагааны хүрээнд хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг ажил олгогчдоос ирүүлж буй ажлын сул байрны захиалгаар, нийлүүлэлтийг ажиллахад бэлэн ажил идэвхтэй хайж буй бүртгэлтэй ажилгүй иргэдээр тооцож байгаа ба ажлын байрны хомсдолоос шалтгаалан эрэлт, нийлүүлэлтийн харьцаа харилцан адилгүй байна.

Ажил олгогчдоос ирүүлсэн ажлын байрны захиалгын ашиглалт аймаг нийслэлд ялгаатай байна. Тухайлбал аймгийн дунджаар 97 хувьтай байхад нийслэлд 52,9 хувьтай байна. Улсын хэмжээнд ажлын байрны ашиглалт 73 хувьтай байна.


Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг ажил олгогчдоос ирүүлж буй ажлын байрны захиалгаар, нийлүүлэлтийг ажил идэвхтэй хайж буй бүртгэлтэй иргэдээр тооцов. Энэ харьцаа 2,45 хувьтай байна.



Зураг 8. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, 2015-2017 он

Улсын хэмжээнд 2017 оны 12 сард нийт **22584** ажлын шинэ байр бий болж, түүнд ажилгүй иргэдийг бүрэн байршуулсан байна.

Тухайн нутаг дэвсгэр дээрх шинээр байгуулагдсан салбар нэгжүүд буюу шинээр бий болж байгаа ажлын байрыг бүртгэж мэдээллийг нэгтгэн гаргаж байна. Тайлант хугацаанд нийт **5240** ажлын шинэ байрыг бүртгэж тухайн ажлын байранд ажилд орсон иргэдийн мэдээллээр баталгаажуулсан байна. Ажлын шинэ байранд ажилд орсон иргэдийг өмнөх оны мөн үетэй харьцуулан авч үзвэл **6696** хүнээр буурч **19,3** хувиар буурсан үзүүлэлттэй байна.



Зураг 13. Ажлын шинэ байранд орсон иргэд

Хүснэгт 6. Ажлын шинэ байранд ажилд орсон иргэдийг байршлаар, хүйсээр.

Байршил	Ажлын шинэ байранд ажилд орсон хүний тоо	
	Бүгд:	Эмэгтэй
Баруун бүс-Дүн	5062	2285
Баян-Өлгий	991	432
Говь-Алтай	1276	570
Завхан	1107	569
Увс	1134	481
Ховд	554	233
Хангайн бүс-Дүн	7087	3621
Архангай	1399	738
Баянхонгор	647	276
Булган	1605	701
Орхон	918	559
Өвөрхангай	950	562
Хөвсгөл	1568	785
Төвийн бүс-Дүн	4605	2106
Говьсүмбэр	117	79
Дархан	912	398
Дорноговь	810	303
Дундговь	90	39
Өмнөговь	677	365
Сэлэнгэ	1184	495
Төв	815	427
Зүүн бүс-Дүн	2039	758
Дорнод	911	312
Сүхбаатар	517	210
Хэнтий	611	236
Улаанбаатар	9031	5162
Хан-Уул	29	22
Багануур	39	30
Баянзүрх	848	553
Налайх	1957	1069
Баянгол	424	233
Сүхбаатар	2055	1252
Чингэлтэй	948	495
Багахангай	2041	1149
Сонгинохайрхан	690	359
УЛСЫН ДҮН	27824	13932

Үүнээс харахад жил бүрийн ажлын байрны тоо харилцан адилгүй байгаа нь харагдаж байна. Энэ нь /өсөлт бууралт/ тухайн жилийн онцлог, хөрөнгийн эх үүсвэр, хэрэгжүүлж буй арга хэмжээ, үйл ажиллагаа, төр засгийн бодлого шийдвэртэй холбоотой нь ажиглагдаж байна.

Зам тээврийн судалгаа

- Монгол Улсын авто замын салбарын бүтэц, бүрэлдэхүүн
- Улсын чанартай авто замын сүлжээний өнөөгийн байдал
- Авто замын салбарт 2018 онд улсын төсөв, гадаадын зээл, тусламж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй, төсөл, арга хэмжээнүүд

Өнөөгийн байдлын судалгаагаар цуглуулсан материалууд /Нийслэл, аймаг, сум, баг, хорооны түвшинд хүн амын тоо, нас хүйсний бүтэц, ХАА, МАА-н үйлдвэрлэлийн хэмжээ, хөдөлмөр эрхлэлт, төсвийн байгууллагуудын ажилтнуудын тоо, зэрэг мэдээллүүдийг цуглуулж боловсруулалт хийж байна.

3.7.2 Газар ашиглалт, газар зохион байгуулалтын судалгаа

Газар ашиглалт, газар зохион байгуулалтын чиглэлээр одоо боловсруулж буй улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төсөлтэй танилцаж ... чиглэлээр санал боловсруулж хүргүүлсэн мөн газрын нэгдмэл сангийн тайлангуудыг шаардлагатай он тус бүрээр харьцуулан судалж байна. Мөн улс, аймаг, сум, баг, хорооны хил хязгаар, засаг захиргааны нэгжийн төвүүдийг зурагт оруулж зураглалын суурь бэлтгэж байна..

Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төсөл

Улсын газрын нэгдмэл сангийн тайлан /2016,2017 он/

Газрын сэдэвчилсэн зураглал, мэдээллийн сангийн хүрээнд:

- Хүн амын нягтшил/Сумын хэмжээнд//2017 оноор/
- Аймаг нийслэл, сум дүүргийн хүн амын байдал/2017 оноор/
- Томоохон гол мөрд дагасан хүн амын байдал/2017 оноор/
- Хүн амын шилжилт хөдөлгөөнийг аймгууд болон нийслэлийн хэмжээнд/2010-2017 оны хугацаанд/
- Хүн амын шилжилт хөдөлгөөнийг бүсийн хэмжээнд/2010, 2017 оны хэмжээнд/
- Сумдын хүн амын өөрчлөлтийн байдал 1990, 2000, 2010, 2017 оны байдлаар
- Хүн амын ачаалалыг насны ангилалаар /хүүхэд, өндөр настанаар/2010 болон 2017 оны байдлаар/
- ОХУ болон БНХАУ-тай хиллэх сумын хүн амын байдал, сумдын тоо
- Улсын чанартай авто зам, хатуу хучилттай замтай холбогдсон сумд
- Аймаг нийслэлийн эдийн засгийн байдлыг дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээгээр/2000, 2010, 2017 оны хэмжээнд/
- Хот хөдөөгийн өрхийн тоог 2017 оны байдлаар аймгууд болон нийслэлийн хэмжээнд тус тус гарган зураглалыг хийж гүйцэтгэв.
- 2017 оны байдлаар нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийгдсэн сумдын сэдэвчилсэн зураглалуудыг хийж гүйцэтгэсэн.
- Холбогдох тоон мэдээллийн сан үүсгэн баяжуулан ажиллаж байна.
- Зүүн хойд азийн бүс нутгийн эдийн засгийн интеграцийн сэдэвчилсэн зураглал
- Сумдын Нутаг дэвсгэрийн төлөвлөгөө хийгдсэн байдал

- Монгол Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төсөл

Дээрх судалгааг хийж гүйцэтгэхдээ “Үндэсний статистикийн хорооны статистик үзүүлэлт тоон мэдээлэл”, “Улсын газар зохион байгуулалтын 2017 оны тайлан” зэрэгт тусгагдсан тоон мэдээллүүдийг ашиглан ArcGis программ хангамж дээр сэдэвчилсэн зураглалыг хийсэн.

IV. ОРОН НУТГИЙН СУДАЛГАА

Төвийн захирлын 2018 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр баталсан удирдамжийн дагуу нийт Төвийн бүсийн 27 сумдад “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийг боловсруулах ажлын хэсгийг мэдээ, мэдээллээр хангахаар байгуулагдсан орон нутгийн ажлын хэсгийнхэнтэй уулзалт зохион байгуулах, мэдээ, материал цуглуулахаар Хүн амын нутагшилт, бүс нутгийн судалгаа төлөвлөлтийн хэлтсийн дарга С.Давааням судалгааны I-р багийг ахалж тус хэлтсийн газарзүйч, бүс нутаг судлаач Г.Балжмаа, хот төлөвлөлтийн эдийн засагч Г.Баттуяа, газар зохион байгуулагч Б.Идэрхангай, Хот суурин дэд бүтцийн судалгаа төлөвлөлтийн хэлтсийн дэд бүтцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Ганпүрэв нар, Барилгын хөгжлийн төвийн Хүн амын нутагшилт, бүс нутгийн судалгаа, төлөвлөлтийн хэлтсийн газарзүйч, бүс нутаг судлаач Д.Отгонбат судалгааны II-р багийг ахалж, хот төлөвлөлтийн архитектор Б.Батхишиг, Хот суурин, дэд бүтцийн судалгаа, төлөвлөлтийн хэлтсийн архитектор Б.Цолмон, инженер геологич Ж.Түвшинбаяр нар 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс 2018 оны 12 дугаар сарын 10-ны өдрийг дуустал 10 хоногийн хугацаатай албан томилолтоор ажиллав.

Ажлын зорилго: Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг бүс нутаг, бүлэг суурингийн тогтолцоог оновчтой тогтоох чиглэлээр үе шаттайгаар боловсруулна”, Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 2.79-д “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг боловсруулах”, мөн Засгийн газрын 2017 оны 05 дугаар тогтоолд “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг боловсруулах”-аар тус тус заасныг хэрэгжүүлэх зорилгоор “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн танилцуулга хийх, анхан шатны шаардлагатай нийгэм-эдийн засгийн мэдээ, материал цуглуулах, орон нутгийн саналыг тусгах, орон нутагт байгуулагдсан ажлын хэсэгтэй хамтарч ажиллахад оршино.

“Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн орон нутаг дахь ажлын хэсгийг хуралдуулж мэдээлэл өгөх. Сэлэнгэ аймгийн засаг даргын 2018 оны 11 сарын 19-ний өдрийн А/417 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг мөн Дархан-Уул аймгийн засаг даргын 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 01-А/328 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг, Төв аймгийн засаг даргын 2018 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн А/506 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгүүдийг тус тус хуралдуулж багийн ахлагч С.Давааням Монгол Улсын хүн амын нутаг шилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн талаар танилцуулга мэдээлэл хийлээ. Мөн эдгээр аймгууд өнөөгийн байдлын талаар танилцуулга хийсэн бөгөөд хурлын тэмдэглэлийг хөтөлж хавсаргав.

Аймаг, сумаас нийгэм-эдийн засгийн статистик мэдээлэл цуглуулах БХБЯ-ны сайдын албан бичиг мөн судалгааны 31 хүснэгтийг хавсралтаар орон нутагт хүлээлгэн өгч ажлын 10 хоногт судалгааг маягтын дагуу гаргуулж авахаар тохирч холбогдох мэргэжилтний утасны дугаар мэйл хаягийг тэмдэглэн авсан. Тухайн аймаг сумын хэвлэмэл танилцуулга, ойн ном болох бусад холбогдох материалуудыг цуглуулж авлаа.

Аймгийн ерөнхий архитектороос мэдээ материал солилцох Сэлэнгэ аймгийн ерөнхий архитектор Б.Хангал, Төв аймгийн ерөнхий архитектор Д.Алтансүх, Дархан-Уул аймгийн ГХБХБГ-ын барилгын хэлтсийн дарга Олонбаяртай тус тус уулзаж аймгийн төв болон сумдын ерөнхий төлөвлөгөө хийгдсэн байдал, хэрэгжилтийн талаар мэдээлэл авч боловсруулсан ерөнхий төлөвлөгөөг файлаар авлаа.

Аймаг, сумын хөгжлийн бодлогын баримт бичигтэй танилцаж, хувилж авах. Судалгаанд хамрагдсан аймаг сумдын батлагдсан хөгжлийн бодлогын баримт бичгийг цаасаар авч цуглуулсан.

Судалгааны маршрут-1: Улаанбаатар - ТӨ. Бүрэн – ТӨ.Өндөрширээт-ТӨ. Лүн - ТӨ. Заамар - ТӨ. Цээл - СЭ. Сайхан/Хөтөл/ - СЭ.Орхон - СЭ. Сүхбаатар хот - СЭ. Жавхлант - ДА. Дархан хот – ДА. Шарын-гол - СЭ. Баянгол - СЭ. Мандал - ТӨ. Зуунмод – ТӨ. Сэргэлэн – Улаанбаатар

Судалгааны маршрут-2: Улаанбаатар - Да. Хонгор - Дархан Орхон - СЭ. Шаамар – Сэ Дулаанхаан - СЭ. Зүүнбүрэн - СЭ. Цагааннуур - СЭ. Түшиг - СЭ. Сүхбаатар хот - СЭ. Алтанбулаг - СЭ. Ерөө /Бугант/ - ДА. Дархан хот – Дархан Шарын гол - СЭ. Баянгол - СЭ. Мандал – Сэ /Түнхэл/ - ТӨ. Баянчандмань - ТӨ. Баянцогт - ТӨ. Баянхангай - ТӨ. Аргалант - Улаанбаатар

Хүснэгт 21. Томилолтоор ажиллах хугацаанд цуглуулсан мэдээ материалуудын жагсаалт

№	Аймаг сум	Агуулга	Хуудас	Хэвлэгдсэн он
1	Төв аймгийн Бүрэн сум	Сумын танилцуулга	3	2018
2	Төв аймгийн Бүрэн сум	Сумын 2018 оны төсөв батлах тухай ИТХ-ын тогтоолын хуулбар	8	2017.12
3	Төв аймгийн Бүрэн сум	Сумын 2018 оны 10-р сарын гүйцэтгэлийн мэдээ	1	2018.10
4	Төв аймаг Өндөрширээт сум	Сумын ерөнхий танилцуулга	8	2018.1
5	Төв аймгийн Лүн сум	Танилцуулга	1	2018
6	Төв аймгийн Цээл сум	Танилцуулга	2	2017
7	Төв аймгийн Цээл сум	Улсын бүртгэлийн сар бүрийн мэдээ	1	2017
8	Төв аймаг Өндөрширээт сум	Сумын ерөнхий танилцуулга	8	2018.3
9	Төв аймаг Заамар сум	Төв аймгийн Заамар сумын уул уурхайн ил тод байдлын мэдээлэл	8 хуудас	2016
10	Төв аймаг Заамар сум	Төв аймаг Заамар сум Алтан ураг Арт галарей	17	2018
11	Төв аймаг Заамар	Заамар сумын хүн ам,	1	1996-2017

	сум	хөдөлмөрийн нөөц, хүн амын нийгмийн үзүүлэлтүүд		
12	Төв аймаг Заамар сум	Магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувиллын үйлчилгээ үзүүлэх байгуулагуудын жагсаалт	1	2018
13	Төв аймаг Заамар сум	Заамар сумын нийгэм эдийн засгийн статистик судалгаа	1	2017.12.31
14	Төв аймаг Заамар сум	Заамар сумын газрын төлбөр төлөгч ААН-үүдийн жагсаалт	3	2017
15	Дархан-Уул аймаг Шарын гол сум	Танилцуулга	8	2017
16	Дархан-Уул аймаг	Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө-2030	119	2017
17	Сэлэнгэ аймаг Сайхан сум	Сайхан сумын 2018 оны хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт	1	2018
18	Сэлэнгэ аймаг	Сэлэнгэ аймгийн аялал жуулчлалын хөгжлийн стратеги (2018-2022)	18	2017
19	Сэлэнгэ аймаг	Сэлэнгэ аймгийн аялал жуулчлалын зураг	1	2017
20	Сэлэнгэ аймаг	Хөтөч ном Аялал жуулчлал	1	2017
21	Сэлэнгэ аймаг Жавхлант сум	Заяа түшсэн Жавхлант-II дэд дэвтэр	211	2018
22	Сэлэнгэ аймаг Жавхлант сум	Жавхлант сайхан нутаг баримтат кино	1ш cd	2018
23	Сэлэнгэ аймаг	Зарим газар нутгийг бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авах тухай	20	2018
24	Сэлэнгэ аймаг	Аймгийн тусгай хэрэгцээний газрын өөрчлөн тогтоох тухай	2	2018.07.02
25	Сэлэнгэ аймаг	Хот байгуулалтын баримт бичгийн талаархи судалгаа	1	2015
26	Сэлэнгэ аймаг	Тариалангийн бүс нутгийг тогтоох тухай	1	2018
27	Сэлэнгэ аймаг Орхон сум	Сэлэнгэ аймаг Орхон сум	31	2010
28	ГЗБГЗЗГ	Газрын харилцааны мэдээлэл	104	2018
29	ГЗБГЗЗГ	Монгол орны бэлчээрийн иөлөв байдлын үндэсний тайлан	66	2018
30	Дархан-Уул аймаг	Дархан-Уул аймгийн судалгаа	Нийт 31 Маягтын дагуу	2018
31	Дархан-Уул аймаг	Аймаг, сум суурингуудын нутаг дэвсгэрт газар хөдлөлийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн	137	2017

		инженери-геологи, гидрогеологи, газар хөдлөл, техникийн судалгаа		
--	--	--	--	--

4.5 ДАРХАН-УУЛ АЙМАГ

1. ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН ХОТ

Дархан-Уул аймгийн засаг даргын 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 01-А/328 дугаар захирамжаар байгуулагдсан “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг боловсруулахад аймгийн асуудлыг тусгах, төсөл боловсруулах багийг шаардлагатай мэдээ мэдээллээр хангах орон нутагт ажиллахад дэмжлэг үзүүлэх, хамтарч ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийн хурлыг аймгийн нутгийн удирдлагын ордны хурлын танхимд зохион байгууллаа. Ажлын хэсгийн хурлын эхэнд Монгол улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн талаар товч танилцуулгыг ХАНБНСТХ-ийн дарга С.Давааням хийв. Үүний дараа аймгийн талаас өнөөгийн байдлын танилцуулгыг хийлээ.

1961 онд Дархан өртөөний суурин дээр байгуулагдсан. Хараа голын сав газарт байрладаг. 327,5 мянган га нутаг дэвсгэртэй. 101800 хүн амтай. Гадаад харилцааны хувьд 17 орны аймаг хотуудтай харилцаатай ажилладаг. 19000 суралцагч, 5700 оюутантай. 1 нэгдсэн эмнэлэг, 5 өрхийн эрүүл мэндийн төвтэй. Дулаан цахилгааны өөрийн эх үүсвэртэй. ДНБ-ий ХАА-9,6%, Үйлдвэрлэл 42,2%, Үйлчилгээ-48,2%-ийг эзэлдэг. ДНБ-386.883,6 сая төгрөг.

Газар нутаг багатай.

Дархан сум Засаг захиргааны 18 багтай. 1 баг 5-6 мянган хүн амтай. Багт төрийн үйлчилгээг 3 төрийн албан хаагч хүргэж байна.

Сэлэнгэ аймаг Дархан-Уул аймаг ИТХ-аар нэгдэх тухай шийдвэр гарч байсан.

Аялал жуулчлал. Аялал жуулчлалын мастер төлөвлөгөөг батлуулсан. Хотын аялал жуулчлалын маршрут гаргасан.

Дэд бүтэц. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр цэвэрлэх байгууламж баригдаж байна. 20 сая долларын төсөвт өртөгтэй. Дархан хот нь хоногт 8-12000м3 бохир ус зайлуулдаг. Уг төслийг Герман-Италийн консерциум шалгаран гүйцэтгэж байна. Төсөл хэрэгжсэнээр 24000 м3/хоногт бохир ус татан зайлуулах хүчин чадалтай болох юм.

Дархан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Арт констракшн ХХК боловсруулж байна.

Аймгийн цогц бодлогын баримт бичгийг 2009 онд баталсан.

Аймгийн санал:

1. АШУИС, ШУТИС, Политехник коллеж нийт 10 их дээд сургууль байна. Бүгд дотуур байртай. Анги танхим хүрэлцээтэй. Улаанбаатарт байгаа их дээд сургуулиудыг Дархан хот руу нүүлгэх
2. ШУ-ы хүрээлэн, хүрээлэнгүүдийг Дарханд төвлөрүүлэх, Малын удмын сангийн цогцолбор 150-180 хүний ажлын байр бий болсон. Малын ген, ашиг шим сайжруулан өндөр ашиг шимтэй малын генийг хадгалах, үржүүлэх энэ цогцолборыг ашиглах
3. Арьс ширний үйлдвэрүүдийг Дарханд төвлөрүүлэх, ажиллах хүчний нөөц мөн цэвэрлэх байгууламжийг түшиглэх

2. ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМ

Монгол улс “Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийг боловсруулхад дэмжлэг үзүүлэх багийн бүрэлдэхүүнийг Сайд Баделханы 2018 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн 01/2797 тоотыг орон нутагт байгуулсанаар ажлын хэсэгт мэдээ мэдээлэл өгөх болон судалгааны 31 маягтын дагуу боловсруулагдах ажлуудыг хийсэн болно. Судалгааг манай 2-р баг нь Хонгор сумын нутгаас эхэлж, М.Атархишиг Засаг даргад багийн ахлагч Д.Отгонбат ХАНСЕТ-ийн танилцуулгыг албан ёсоор хийж, хийж, ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлагыг хийж, судалгааны асуулгын 31 маягтыг 2018 оны 12 дугаар сарын 15-ны авахаар болсон.

3. ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ОРХОН СУМ

Дархан-Уул аймгийн Орхон сумын Засаг даргын тамгын газрын дарга Б.Түмэнцогт-д, Газрын даамал Г. Мөрөн хоёрт ХАНСЕТ-ийн талаарх товч мэдээлэл өгч, ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлагыг хийж, судалгааны асуулгын 31 маягтыг 2018 оны 12 дугаар сарын 15-ны авахаар болсон.



Зураг 1. Дархан-Уул аймгийн Орхон сумын удирдлагатай хийсэн уулзалт



Зураг 2. Болгарын хөрөнгө оруулалтаар босгосон нарийн ногоо нөөшлөх үйлдвэр





Зураг 3. Сумын ерөнхий байдал

4. ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ШАРЫН ГОЛ СУМ

Сумын Засаг даргын тамгын газарт ИТХ-ын дарга, газрын даамал Оюундарьтай судалгааны багийн гишүүд болох БХТ-ийн ХАНБНСТХ-ийн дарга С.Давааням, мэргэжилтэн Д.Отгонбат, Б.Батхишиг, Г.Балжмаа, Г.Баттуяа, Б.Идэрхангай, Б.Ганпүрэв, Б.Цолмон, Ж.Түвшинбаяр нар уулзалт хийж МУ-ын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн талаархи танилцуулгыг хийж сумын одоогийн нийгэм эдийн засгийн байдлын талаар мэдээлэл авч харилцан мэдээлэл солилцож ажиллав.

Өнөөгийн байдал. 8300 гаруй хүн амтай. Алтны нинжа буюу хөдөлгөөнт хүн ам 2000 гаруй хүн байдаг. Төмөр замаар холбогдсон. 2016-2020 оны мөрийн хөтөлбөрт 48 км авто зам тавихаар тусгагдсан. Нүүрсний уурхай жилд 1 сая тонн нүүрс олборлодог. Дулаан Шарын гол компани дулаанаа хариуцдаг. Зуны улиралд алтны 3 орд ашиглалт явуулдаг. 2 сургуультай. Жилдээ 300 сая төгрөгний хөрөнөг оруулалт авдаг. Алтны уурхайгаас 35 сая төгрөгний хөрөнгө оруулалт авсан. Нүүрсээ Дархан, Эрдэнэт ТЭЦ-г хангадаг. Хотын 3-р цахилгаан станцад нүүрсээ өгдөг. Нүүрс угаадаг тоног төхөөрмж сайн ажиллахгүй байна. 300 сая тонн нүүрсний нөөцтэй гэж нөөц нь тогтоогдсон. Уурхай жилд 1,5 сая тонн нүүрс олборлоод 500 мянган тонныг экспорт, 1 сая тонн-ыг дотооддоо борлуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. 500 орчим ажиллагсадтай.

“Тулга” мэргэжлээс шалтгаалах өвчний сувилал хэлбэрээр эмнэлгийг ашиглаж байна. Тус сум нь социализмийн үед 11000 орчим хүн амтай байсан. Хүн амын шилжилт хөдөлгөөн бага тогтвортой байна. Бэлчээрийн талбай бага. 1767 га уурхайн эдэлбэр газар. 742 өрх 5 давхар 15ш орон сууцанд, 2 давхар орон сууцанд 324 өрх, гэр хороололд 1100 өрх, хөдөөд 130 өрх амьдардаг. Дархан хоттой таталцдаг. Ерөнхий төлөвлөгөөний дагуу газар олголтыг хийж байна. Уул уурхайн хувьд нүүрсний 1, алтны 4 лиценз олгогдсон, хайгуулын лицензтэй 2 газар бий.

Тулгамдсан асуудал: Дархан болон Баянгол сумтай авто замаар холбогдох

4.6 СЭЛЭНГЭ АЙМАГ

1. СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМ

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Засаг даргын орлогч дарга Батцэнгэл, Газрын даамал Мөнхзаяа хоёрт ХАНСЕТ-ийн талаарх товч мэдээлэл өгч 2-р багийн ахлагч Д.Отгонбат ХАНСЕТ-ийн танилцуулгыг албан ёсоор хийж, ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлагыг хийж, судалгааны асуулгын 31 маягтыг 2018 оны 12 дугаар сарын 15-ны авахаар болсон.



Зураг 4. Сэлэнгэ аймгийн Ерөө сумын удирдлагатай хийсэн уулзалт



2. СЭЛЭНГЭ АЙМГИЙН САЙХАН СУМ

Засаг даргын орлогч Үүрдмөнхтэй уулзаж төслийн талаар танилцуулга хийж, орон нутгийн өнөөгийн байдлын талаар мэдээлэл авч ажиллав. Сум орон нутгийн талаар товч танилцуулга: Сэлэнгэ аймагт эхний 3-т ордог. Томоохон 2 үйлдвэртэй. Хөтөлийн цемент шохойн үйлдвэр 800, Төмөр замын бетон дэрний үйлдвэр 250-300 ажиллагсадтай. Сант, Орхон, Орхонтуул, Баруунбүрэн сумын тулгуур төв юм. Газар нутгийн хилийн цэсийн маргаантай. Суурьшлын гэр хороолол нь Орхон сумын нутагт харяалагддаг. Тус сумын Ширээ нуруу гэдэг газарт суурьшлын бүс үүссэн. Энэ нь Сайхан сумын нутаг боловч Дарханы иргэд суурьшсан. 3 багтай. 1 тосгонтой. 550 орчим төрийн албан хаагчтай. 2 сургууль 4 цэцэрлэгтэй. 2,3-р багийн нутаг дэвсгэр газар тариалангийн бүс нутаг болохоор батлагдсан. 93000 толгой малтай. 1500 хүүхдийн хүчин чадалтай 12 жилийн сургуульд 1950 орчим сурагч суралцаж байна. 480 хүүхдийн суудалтай сургууль шинэр баригдаж байна. Сургалтын чанар сайн учраас зэргэлдээх сумдаас хүүхдүүд ирж суралцдаг. 300 орчим хүүхэд өөр сумдаас ирж суралцдаг гэсэн судалгаа бий. Энэ нь хүүхдийн аюулгүй байдалд сөрөг нөлөөтэй. 2 баг 4500 орчим иргэнтэй. Багуудаа хуваахаар судалгаа хийж байна. Тосгоны захирагчийн алба ажилладаг. 20-иод албан хаагчтай. Сайхан сумын ерөнхий төлөвлөгөөг анх байгуулагдсанаас хойш хийгээгүй. Хот төлөвлөлтийн баримт бичигтэй болох шаардлагатай байна. Хөтөлийн цемент шохойн 2 ордын 1 орд нь Орхон сумын газарт оршдог. Тус үйлдвэрээс нийгмийн хариуцлагын хүрээнд ажил бага хийдэг оролцоо сул.

Аялал жуулчлал. 2 жуулчны бааз үйл ажиллагаа явуулдаг. Хараа голын дагуу байрладаг. Ширэг нуур, Алтан хундага ахмадын амралт сувиллын 2 газартай. Инженерийн шугам сүлжээ 30 гаруй жил болж муудсан.

Номгон тосгон 1200 гаруй хүн амтай. Хуучин газар тариалангийн сангийн аж ахуй байсан. Тосгонд 1 сургуультай. Сүүлийн 2 жилд 700 сая төгрөгний хөрөнгө оруулалт хийгдсэн. Шилжилт хөдөлгөөн бага.

Сум дундын төвөөрөө улам томрон хөгжих бодлого барьж ажиллаж байна.

Хүрээлэн буй орчны хувьд цемент шохойн үйлдвэр 35 жил болж байна. Цементийн үйлдвэр улирлын чанартай зогсолт хийдэг. Шохойны утаа өвөл зунгүй агаарыг бохирдуулдаг. Агаарын чанар байх түвшингээс 3 дахин их, үйлдвэрийн орчинд 11 дахин их бохирдсон гэсэн шинжилгээний дүн бий. ИТХ-аас тогтоол гарч шохойн утааг багасгах талаар арга хэмжээ авах ажлын хэсэг байгуулсан.

Усны хувьд Орхон голоос 22 км-ээс усаа татдаг. Цэвэрлэх байгууламжтай. 26 орон сууцтай. 5 давхар 2 орон сууц шинээр ашиглалтанд орсон. Орхон Сант сумдыг өөртөө нгэтгэх бодлого барьж байна. Дэд бүтэц эрүүл ахуйн 2 мэргэжилтэнтэй. Гавшгай ус суваг 100 орчим ажилтантай.

Тулгамдсан асуудал:

- Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг яаралтай хийлгэх, агаарын бохирдол шохойн утааг багасгах арга хэмжээ авах, газар нутгийн хилийн цэсийн маргааныг шийдвэрлэх

3. СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОН СУМ

Орхон сумын Засаг даргын тамгын газарт ХАА-н тасгийн мэргэжилтэн Түшигбаяр, 1-р багийн Засаг дарга Сийлэгмаа, Санхүүгийн албаны дарга Оюун-Эрдэнэ, Төрийн сангийн мэргэжилтэн Уянга нартай уулзалт хийлээ. Сайхан сум буюу Хөтөлөөс 13 км. Авто замаар холбогдсон. Сайхан сумруу татагддаг.

2376 хүн ам, 848 өрхтэй. 2 багтай. 1 баг 356, 2-р баг 321 өрхтэй. 2017 оны байдлаар 104976 мал тоолуулсан. Төрийн 5 байгууллагатай. 500 хүүхдийн хүчин чадалтай сургуульд 279 сурагч суралцаж байна. 12 жилийн сургалттай. Анги 1 бүлэгтэй.

Орхон сумын хөгжлийн тэргүүлэх салбар нь газар тариалан, мал аж ахуй. 2500 га эргэлтийн талбайтай. 130,6 мянган га нутаг дэвсгэртэй. Үр тариа, төмс хүнсний ногоо, тосны ургамал тариалдаг. Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийгдээгүй. Бүртгэлтэй 89 аж ахуй нэгж байдгаас 37 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна.

Аялал жуулчлалын хувьд Гуулин улсын цаасны үйлдвэрийн туурь, Хадан дээрхи Бурхан (Занабазарын үед хийгдсэн), түргийн үеийн буган хөшөө, 200 гаруй хиргисүүр тоологдсон. Жуулчны бааз байхгүй. Амралт сувилал байхгүй.

Инженерийн шугам сүлжээний хувьд байгууллага бүр нам даралтын зуухтай. Цэвэр бохир усны шугам байхгүй.

Шилжилт хөдөлгөөн. Баруун аймгуудаас малтай айлууд шилжиж ирдэг. Сүүлийн 2 жилд зогссон.

Дархан, Хөтөл рүү хүчтэй татагддаг.

Өрхийн амжиргааг дээшлүүлэх зорилгоор өрх бүр 1-3 га газартай болгох бодлого барьж байна. Малжуулах хөтөлбөр жил бүр хэрэгждэг.

Тулгамдсан асуудал:

- Сумын төвийн хүн ам бага Дархан, Хөтөл рүү татагддаг, Сайхан сумтай газар нутгийн маргаантай, хөгжил сул, эдийн засгийн хувьд өрсөлдөх чадвар бага

4. СЭЛЭНГЭ АЙМГИЙН БАЯНГОЛ СУМ

Сумын Засаг даргын тамгын газарт ЗДТГ-ын дарга Б.Эрдэнэбаатар судалгааны багийн гишүүд болох БХТ-ийн ХАНБНСТХ-ийн дарга С.Давааням, мэргэжилтэн Д.Отгонбат, Б.Батхишиг, Г.Балжмаа, Г.Баттуяа, Б.Идэрхангай, Б.Ганпүрэв, Б.Цолмон, Ж.Түвшинбаяр нар уулзалт хийж МУ-ын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн талаархи танилцуулгыг хийж сумын одоогийн нийгэм эдийн засгийн байдлын талаар мэдээлэл авч харилцан мэдээлэл солилцож ажиллав. Сумын өнөөгийн байдал. 197,6 мянган га талбайтай. Үүнээс хадлан 10613, ХАА 152,46 га. 2017 оны жилийн эцсийн байдлаар 5600 хүн амтай. Засаг захиргааны 3 нэгжтэй. Сумын стратеги төлөвлөгөөг баталсан. Ургамлын тосны үйлдвэр, Замаскны үйлдвэр, бетон зуурмагны үйлдвэртэй. МУ-ын тэргүүний сургуультай. Цэцэрлэгийн хүчин чадал хэтрэлттэй. Сүмбэр сумаас 10 жилийн сургуульд ирж суралцдаг. Бороо гоулд, Сэлэнгэ ресс гэсэн уурхайтай. Дэд бүтцийн хувьд төв магистрал шугам хуучирсан. Халаалтын зуухыг шинэчилсэн боловч шугамууд шинэчлэгдээгүй. Шугам ачааллаа дийлэхгүй нөхцөл байдал үүссэн. 1 уурын зуухтай. Хүн амын шилжилт хөдөлгөөн харьцангуй тогтвортой. Малын тоо толгойг тодорхой хэмжээнд барих бодлого явуулж байна. Ногоочид зориулалтын зоориудтай. Аялал жуулчлал хөгжөөгүй. Үйл ажиллагаа явуулж байгаа уурхайнуудаас жилд 2 тэрбум төгрөгийг усны төлбөрт өгдөг боловч орон нутагт ордоггүй. Тус сумын нутагт хар рапсын ургамлын тосны үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна. Уг үйлдвэр нь дотоодын хэрэгцээг хангаад зогсохгүй гадаад руу экспортонд гаргах зорилготой. Ургамлын тосны хувьд амт үнэргүй сайн чанарын тос үйлдвэрлэж байна. Мөн эко түлш гаргаж өөрийн хэрэгцээнд ашигладаг.

- *Тулгамдсан асуудал:* Төвийн инженерийн шугам сүлжээг шинэчлэх,

5. СЭЛЭНГЭ АЙМГИЙН СҮХБААТАР ХОТ

Сэлэнгэ аймгийн засаг даргын 2018 оны 11 сарын 19-ний өдрийн А/417 дугаар захирамжаар байгуулагдсан “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг боловсруулахад аймгийн асуудлыг тусгах, төсөл боловсруулах багийг шаардлагатай мэдээ мэдээллээр хангах орон нутагт ажиллахад дэмжлэг үзүүлэх, хамтарч ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийн хурлыг аймгийн нутгийн удирдлагын ордны хурлын танхимд зохион байгууллаа. Ажлын хэсгийн хурлын эхэнд Монгол улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн талаар товч танилцуулгыг ХАНБНСТХ-ийн дарга С.Давааням хийв. Үүний дараа аймгийн талаас өнөөгийн байдлын танилцуулгыг хийв.

Аймгийн өнөөгийн байдал. Сэлэнгэ аймаг нь 17 сумтай. Хотжилтийн түвшин өндөр. Мандал сум 25000 хүн амтай. Аймгийн нутаг дэвсгэрийн 5 бүс болгон хуваасан. Сэлэнгэ аймаг 108000 хүн амтай. Хил дамнасан аялал жуулчлал хөгжүүлэх чиглэлийг барьж байна. Сүхбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2013 онд Арт сити ХХК

боловсруулсан. Ерөнхий төлөвлөгөөг барьж байна. Хийсвэр талдаа төлөвлөгдсөн. Аймгийн төвийн суурьшлын хэсэг 1500 га. Нийт 1500 га-д төлөвлөлт хийгдсэн. Төлөвлөлтийн хугацаа 2030 онд 39800 хүн амтай болно гэж төлөвлөсөн. Нийт 17 сумаас 9 сум ерөнхий төлөвлөгөөг хийлгэсэн. Мандал сумын ерөнхий төлөвлөгөөг Инженер геодези ХХК боловсруулж байгаа бөгөөд батлагдаагүй байна.

Аялал жуулчлалын хувьд дотоодын аялал жуулчлал хөгжиж байна. Гадаадын жуулчид бага. Аялал жуулчлалын хөтөлбөр батлагдсан. Сайханы хөтөл дээр шилэн гүүр барих төсөл хэрэгжихээр зураг төслийг БНХАУ-д хийлгэж байна. Амарбаясгалантад жилдээ 2 удаа Бумбаны тахилга болдог бөгөөд энэ үеэр 4-5 мянган хүн ирдэг гэсэн судалгаа байдаг.

- Аялал жуулчлалын маршрут -Ээж мод, Сайханы хөтөл

6. СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЖАВХЛАНТ СУМ

Сумын Засаг даргын тамгын газарт ЗДТГ-ын дарга Бямбадалайтай судалгааны багийн гишүүд болох БХТ-ийн ХАНБНСТХ-ийн дарга С.Давааням, мэргэжилтэн Г.Балжмаа, Г.Баттуяа, Б.Идэрхангай, Б.Ганпүрэв нар уулзалт хийж МУ-ын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн талаархи танилцуулгыг хийж сумын одоогийн нийгэм эдийн засгийн байдлын талаар мэдээлэл авч харилцан мэдээлэл солилцож ажиллав.

Өнөөгийн байдал. 2299 хүн амтай. 84000 малтай. Хөгжлийн тэргүүлэх чиглэл газар тариалан, мал аж ахуй. Төмс хүнсний ногоо тариалдаг. Дархан хот руу зах зээлд ойрхон. Увс, Говь-Алтай аймгаас шилжилт хөдөлгөөн ихтэй. Байгалийн дагалдах баялаг Дэрвэгэр жиргэрүү түүж борлуулан 40 гаруй сая төгрөг төвлөрүүлсэн. 17 аж ахуй нэгжтэй. Ерөө бүсийн хөгжлийн хөтөлбөр гэсэн бодлогын баримт бичиг батлагдсан. Ерөө, Хүдэр, Бугант, Жавхлант сумдууд аймгийн зүүн бүсэд ордог. 12 жилийн сургуультай. 230 хүүхдийн хүчин чадалтай сургуульд 190 гаруй сурагч суралцаж байна. Боловсон хүчин сургалтын чанар өөр тул Дархан хот руу татагддаг. Зарим албан хаагч Дархан хотоос ажилдаа ирдэг.

Ерөнхий төлөвлөгөөг хийлгэхээр 2016 онд зөвлөх үйлчилгээ зарласан боловч гүйцэтгэгч шалгараагүй мөнгө нь буцаж татагдсан. Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө хийгдээгүй. Бүсийн хэмжээний эмнэлэгтэй. Соёлын төв үйл ажиллагаагаараа улсад 2 дугаарт ордог. 2019 онд сумын төв нэгдсэн халаалтын системтэй болно.

Аялал жуулчлал. 2019 онд Норвегийн хөрөнгө оруулалтаар аялал жуулчлалын цогцолбор Эко тур аялал жуулчлалын цогцолор баригдахаар яригдаж байна. Энэ нь нүүдэлчин өв соёлыг харуулсан аялал жуулчлалын төв байх юм. Элсэн мөргөцөг, Бичигт хад гэх мэт байгалийн үзэсгэлэнт газруудтай.

мчилгээний ач холбогдолтой соронзон хад бий. Эрт дээр үеэс тэнгэр дуугарсны дараа уг хаданд очиж хэвтэн саажилт болон бусад өвчнийг эмчилдэг байсан байна.

- *Тулгамдсан асуудал:* Хүн ам цөөн, Дархан хот руу татагддаг, сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө байхгүй.

7. СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАНДАЛ СУМ.

Мандал сумын засаг дарга бөгөөд Баруунхараа хотын захирагч, ИТХ-ын дарга нартай судалгааны багийн гишүүд болох БХТ-ийн ХАНБНСТХ-ийн дарга С.Давааням, мэргэжилтэн Д.Отгонбат, Б.Батхишиг, Г.Балжмаа, Г.Баттуяа, Б.Идэрхангай, Б.Ганпүрэв,

Б.Цолмон, Ж.Түвшинбаяр нар уулзалт хийж МУ-ын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн талаархи танилцуулгыг хийж сумын одоогийн нийгэм эдийн засгийн байдлын талаар мэдээлэл авч харилцан мэдээлэл солилцож ажиллав.

Өнөөгийн байдал. 27180 хүн амтай монгол улсын хамгийн сум. Дэд бүтэц сайн хөгжсөн. 484000 га газар нутагтай. Үүнээс ойн сан, Хан хэнтийн тусгай хамгаалалттай газарт ордог. Политехник коллеж 400 оюутантай. 8-н арван жилийн сургууль, 8 цэцэрлэгтэй. Төр төсвийн 46 байгууллагатай. Сум дундын цагдаа, шүүх, аймагт байх бүх аппарат бий. Сум дотроо 22,5 километр замын зураг хийсэн. Спиртийн үйлдвэр, төмөр зам, вагон депотой. 8-н салаа төмөр замтай. Улсын хэмжээний сүүний 50 хувийг дангаараа хангадаг. Эрт ургацын байцааны 70 хувийг хангадаг. Амжиргааны түвшин өндөр. Ерөнхий төлөвлөгөө 2009 онд хийгдсэн. Төлөвлөгөө хэрэгжээгүй. ИТХ-аар баталсан. 5,3 км бохирын шугамын ажил хийж байна. Шинэ суурьшлын бүс рүү эрчим хүчний шугам татаж байна. 1500 орчим өрх орон сууцанд амьдардаг. 1м2 орон сууцны үнэлгээ 1200 000-1300 000 орчим байна. Орон сууцны хэрэгцээ нэмэгдэж байна. ТОСК 9 давхар орон сууц барьсан. 2018 онд 5,4 давхар 2 орон сууц баригдсан. Эмнэлгийн албан хаагчид орон сууц бариулах хүсэлт гаргасан. Дулааны цахилгаан станц байхгүй. Цэвэрлэх байгууламж хүчин чадлынхаа 30 хувийг ашигладаг. Хоногт 8000м3. 550 гаруй аж ахуйн нэгжтэй. 15000-аас дээш хүн амтай сумыг орон нутгийн хот болгох асуудал яригддаг. Үхэр сүрэг ихтэй. 7000 га-д улаан буудай тариалдаг. 2 тосгонтой. Нийт 9 багтай. Бугант, Түнхэл

Түнхэл тосгоныг сум болгох асуудлыг орон нутгийн ИТХ-аас дэмжээгүй. Үлдсэн 8 багийн иргэдийн хэлэлцүүлэг хийж саналыг тусгаад явуулна. Бугант тосгоны хувьд бие даах боломжтой. Түнхэл тосгон эдийн засгийн хувьд бие даах чадваргүй. Гацуурт төсөл хэрэгжвэл сум болох боломжтой болно гэж тосгоны иргэд үздэг. Мандал сум цэвэр усны эх үүсвэр хамгаалалтгүй. Спиртийн үйлдвэр, төмөр замаас цэвэр усаа авдаг. Хүн ам тогтвортой. Өсөх хандлагатай байна. 17500 га эргэлтийн талбайтай. Захирагчийн ажлын албатай. Бичил уурхай 300 орчим хүн ажиллаж байна.

Аялал жуулчлалын хувьд 6 жуулчны бааз үйл ажиллагаа явуулдаг. Түнхэл тосгонд 2, Тарни багт 2, Мандал сумын төвд 2 байна. Баянгол сумтай газрын маргаантай.

- *Тулгамдсан асуудал.* Барилгын засварын ажилд их мөнгө зарцуулдаг явдлыг эргэж харах, засварын ажил чанаргүй хийгддэг үрэлгэн зардал их гардаг, мөн дээврийн засвар ихэнх барилга чанаргүй баригддаг санхүүгийн чадваргүй компанид тендер өгдөг, эргээд хариуцлага тооцох боломжгүй нөхцөл байдал үүсдэг. Барилгын гадна фассаданд өнгөлгөөний хавтан ашиглах, шинээр баригдсан барилгын фассад маш амархан 1-2 жилийн дотор мууддаг энэ явдлыг салбарын яам анхаарах, Тендерт орж байгаа компаниудад орон нутаг хяналт тавих боломжгүй байна.

4.7 ТӨВ АЙМАГ

1. ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД ХОТ

Төв аймгийн засаг даргын 2018 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн А/506 дугаар захирамжаар байгуулагдсан “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг боловсруулахад аймгийн асуудлыг тусгах, төсөл боловсруулах багийг шаардлагатай мэдээ мэдээллээр хангах орон нутагт ажиллахад дэмжлэг үзүүлэх, хамтарч ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийн хурлыг аймгийн нутгийн удирдлагын ордны хурлын танхимд зохион байгууллаа.

Ажлын хэсгийн хурлын эхэнд Монгол улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн талаар товч танилцуулгыг ХАНБНСТХ-ийн дарга С.Давааням хийв. Үүний дараа аймгийн өнөөгийн байдлын танилцуулга хийж видео танилцуулга хийлээ.

Төв аймаг 27 сумтай үүнээс өнөөдрийн байдлаар 22 сум ерөнхий төлөвлөгөө хийгдсэн. 6 сумын ерөнхий төлөвлөгөөг боловсруулахаар 2019 оны төсөвт мөнгийг тусгуулаад байна. Зуунмод дулааны станцын ТЭЗҮ хийгдэж байна. Манзушир шашин соёлын үйлчилгээний цогцолбор баригдаж байна. Зуунмод гол дагуу амралт зугаалгын бүсийн тохижилт хийгдэж байна. Аймаг 94500 хүн амтай. 1км² 1,27 хүн оногдож байна. Аймагт Аэрфорт сити, Майдар сити, гэх мэтийн хотууд байхаар зураг төсөл хийгдсэн. Гэвч эдгээр зураг төслүүд хоорондоо уялдаа холбоогүй тус тусдаа хийгдсэн тус бүр 200-300 мянган хүн амтай хотууд байхаар зураг төсөл нь хийгдсэн. Аймагт маш олон төсөл хөтөлбөр хэрэгжиж байгаа бөгөөд эдгээрийг төсөлтэй уялдуулах

Аймгийн санал: Тус тусдаа төлөвлөлтүүд хийдэг, 80000 орчим га нутаг дэвсгэртэй том зургаар харж хооронд нь эдгээр төлөвлөлтүүдийг уялдуулж өгөөч гэсэн саналтай байна. Үндэсний хөгжлийн газар дээр загвар аймаг болхоор бодлого барьж байна. 10 гаруй сум авто замаар холбогдсон нэмж 2 сум холбогдно. Давуу болон сул талыг харах, Авто зам, төмөр зам, нисэх онгоцоор холбогдсон байдлыг авч үзэх

2. ТӨВ АЙМГИЙН БҮРЭН СУМ.

Сумын ЗДТГ-ын даргын өрөөнд уулзалт хийлээ. Тамгын газрын дарга н.Янжинсүрэнтэй уулзаж ХАНБНСТХ-ийн дарга С.Давааням төслийн талаар Монгол улсын хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг боловсруулах үндэслэл, шаардлага, Засгийн газрын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрт тусгагдсан байдал, Ерөнхий сайдаар ахлуулсан ажлын хэсэг мөн, аймагт байгуулсан ажлын хэсгийн талаар мэдээлэл өгч төсөл боловсруулах талаар товч танилцуулга хийлээ. Мөн сумын удирдлагуудаас Бүрэн сумын талаар товч танилцуулга хийлээ.

Сумын талаар товч: 3144 хүн амтай . МАА голлосон сум. 5 багтай. Сумын төв Төвхөн баг. 370 гаруй мянган малтай. Шилжилт хөдөлгөөн бага. Амжиргааны түвшин сайн. Сумын нутаг дэвсгэрийн 293 га-д А лицензтэй. Вольфромын Эмгэрийн хошуу одоо үйл ажиллагаа явуулдаггүй. Иргэдийн эсэргүүцэлтэй тулгардаг. 1970 оны орчим ашиглаж байсан.

Өрхийн аж ахуйгаас 2 хоршоо чацаргана тариалдаг. Эсгий үйлдвэрлэл, сүү сүүн бүтээгдэхүүн боловсруулдаг. Замаас алслагдсан. Хувиараа хүн тээвэрлэдэг 10 гаруй машин байдаг. Худалдаа арилжаа хөгжсөн. Таван хошуу малаас хонь давамгай. Зээр ихтэй.

Инженерийн шугам сүлжээ. Төрийн байгууллагууд дулаан цэвэр бохир усны системд холбогдсон. Төв Чандмань компанийн харьяа. Өвөрхангай аймгийн Баянтээгийн уурхайгаас нүүрсээ татдаг. НҮБ, БХБЯ-ны төслөөр Герман технологиор хийгдсэн цэвэрлэх байгууламжтай. 12 жилийн сургуультай. 320 хүүхдийн хүчин чадалтай, 550 сурагч сурч байна. 2019 оны төсөвт бага сургууль баригдахаар мөнгө шийдэгдсэн. Орон нутгийг судлах музейтэй. 10 ортой ӨЭМТ-тэй.

Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Форум арт ХХК 2014 хүлээлгэж өгсөн. Ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилт муу. Шинэ суурьшлын бүсийн төлөвлөлтийг АТТП ХХК 2014 онд хийсэн.

Сумын нутаг дэвсгэрт 6 хайгуул, 6 ашиглалтын лиценз олгогдсон. Одоогоор үйл ажиллагаа явуулж байгаа газар байхгүй. Алт, хүрэн нүүрс, вольфром, төмрийн хүдрийн нөөцтэй. Чулуун суварга, Хүн чулуун хөшөө, Тахилын онгон, Тургийн үеийн булш хиргисүүр элбэг. Газар тариалан хөгжөөгүй. 3-р багийн тал хувь нь Дундговийн Эрдэнэдалай сумаас ирсэн. 100 гаруй мянгат малчинтай. Газар өмчлөлийн байдал 30%. Геодезийн 10 гаруй хатуу цэгтэй. Зочид буудалгүй. Гэр хорооллын зохион байгуулалт сайн. гудамж хоорондын зай ихтэй.

Тулгамдсан асуудал:

- Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу газар олголт хийгдээгүй, ерөнхий төлөвлөгөө 3 жилийн хугацаанд боловсруулж хугацаа алдсанаас газар олголттой уялдаагүй

3. ТӨВ АЙМГИЙН ӨНДӨРШИРЭЭТ СУМ

Сумын өнөөгийн байдлын танилцуулга: Засаг дарга И.Болдбаатар. Тус сум 250000 малтай төрийн 5 байгууллагатай, сургуулийн хувьд 200 хүүхдийн хүчин чадал бүхий ерөнхий боловсролын сургуультай, Хуучин сум сум дундын төв байсан тойргийн 5-6 сумын хүүхдийг хүлээн авдаг байсан. Шилжилт хөдөлгөөн их тойргийн сум 12 жилтэй болсон 1-р сургуультай шефийн харилцаатай эмнэлэг эмчийн хүрэлцээ сайн. Үйлдвэр уурхай аж ахуй байхгүй газар тариалан хөгжөөгүй. Төмс хүнсний ногоо тарих ажлуудыг дэмжин сумын хүнсний хэрэгцээгээ хангах бодлого барьж байна. Усны хүрэлцээ хангамж сайн бохирдол гайгүй. Иргэдийн инженерийн хийцтэй худгуудаас ундны усаа зөөдөг. Туул голоос ундны усаа авдаггүй 7-р сараас хойш цэвэршдэг. Бэлчээрийн газар өвөлжөө хаваржааны нөөцгүй маргаантай 70 гаруй хувьд талхлагдалд орсон тал хээрийн бүс. Элсэрхэг хөрстэй отор нүүдэл хийдэггүй. Сумын төвийн социалзмын үед 60000 малтай байсан Шилжилт хөдөлгөөн ихтэй залуучууд хот руу шилждэг ажлын байр байхгүй. Газар өмчлөл багатай. Сайханы нуруу, Тагийн ус жилдээ 1 угалз 2 буга агнах зөвшөөрөл өгдөг. Төсвийн 5 байгууллага дулааны шугамд холбогдсон. 6 хайгуулын лицензтэй, алт, төмрийн хүдэр аялал жуулчлалын 1 баазтай /Японы бааз/ олон жил үйл ажиллагаа явуулж байна. Япон хүнтэй гэр бүл болох явдал их байна. Аялал жуулчлалын 1 бааз, ахмадын сувилал газрын асуудлыг шийдвэрлэсэн.

Тулгамдсан асуудал:

- Төв рүү чиглэсэн шилжилт хөдөлгөөн ихтэй.

4. ТӨВ АЙМГИЙН ЛҮН СУМ

Сумын өнөөгийн байдлын талаар газрын даамал Ариунболд товч танилцуулга хийлээ. Төв аймгийн Лүн сум нь 1924 онд байгуулагдсан, хуучнаар Түшээт хан аймгийн Мэргэн алтганатай нэрээр байгуулагдсан. Цагаан-Уул, Өгөөмөр, Төв гэсэн 3 багийн 2500 хүн амьдардаг. Хүн амын тоогоор Төв аймгийн 27 сумаас 18-д, газар нутгийн хэмжээгээр 12-д ордог, хүн амын нягтралаар дунд зэрэг сум юм. Төв аймгийн баруун хэсэгт Улаанбаатар хотоос 135 км, Аймгийн төвөөс 175 км зайд байрладаг.

Улаанбаатар хот болон Төв аймгийн Алтанбулаг, Өндөрширээт, Заамар, Угтаал, Баянхангай, Эрдэнэсант, Булган аймгийн Баяннуур, сумдтай хиллэдэг. Ерөнхий төлөвлөгөө АЕСН ХХК хийсэн. Өнөөдрийг хүртэл хүлээлгэж өгөөгүй. Хувийн журмаар ерөнхий төлөвлөгөөний зургийг хуулбарлаж авсан. Аялал жуулчлалын 1 баазтай. Сумын

баруун хэсэгт төв зам дагуу Урьхан зоогийн газар шинээр ашиглалтанд орсон. Дэд бүтэц сайн хөгжсөн. Баруун аймгууд руу явах улсын чанартай авто зам дайран өнгөрдөг. Үйлчилгээ дэд бүтэц хөгжсөн. Газрын төлбөрөөс 2018 онд төсөвт 57 сая төгрөг төвлөрүүлсэн. Ерөнхий төлөвлөгөөний дагуу газрын дуудлага худалдааг 5 байршилд хийсэн. Мянгат малчин ихтэй. Баруун аймгуудаас шилжилт хөдөлгөөн ихтэй. Улаанбаатар хот руу татагддаг. Инженерийн дэд бүтцийн төсөл хэрэгжсэн.

Тулгамдсан асуудал:

- Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг орон нутагт хүлээлгэж өгөөгүй
5. ТӨВ АЙМАГ ЗААМАР СУМ

Засаг даргын орлогч Ичинхорлоо, Иргэдийн хурлын дарга Галтбадрах нартай уулзаж сумын талаар мэдээлэл солилцож төслийн талаар танилцуулж мэдээлэл авлаа. Заамар сумын хувьд алтны уурхай, гар аргаар алт олборлодог. Мөн эвдэрсэн газар ихтэй энэ нь сум орон нутгийн хувьд нэлээд асуудал болж байна.

Сумын хөгжлийн бодлогын баримт бичигтэй уул уурхайтай сум гэдгээр онцлог. 2015 онд ерөнхий төлөвлөгөө Инженер геодези ХХК хийсэн юм. Ашигт малтмалын лиценз 124, олгогдсон 52000 га 50 гаруй компани эзэмшдэг. Хайгуулын 201, ашиглалтын 10 лиценз олгогдсон. Сум 5900 гаруй хүн амтай. Зун 10000 орчим хүнтэй болдог. Сумын төвийн хүн ам 1000 гаруй. Сумын төв инженерийн шугам сүлжээнд холбогдсон. Цэвэр бохир халуун усгүй. 1968 онд баригдсан 28 байшинтай шинээр 2 орон сууц нэмэгдсэн. Сум дундын цагдаагийн хэлтэстэй. Хайлааст багийн нутаг дэвсгэрт хамрагддаг 9 жилийн 12 жилийн сургуультай хувийн 2, төрийн 2 цэцэрлэгтэй МСҮТ-тэй 400 хүүхдийн 300 хүүхдийн дотуур байртай. 2 эмнэлэг 15 ортой, 10 ортой, Соёлын төв спорт заалтай. Хайлааст багт сургууль цэцэрлэг эмнэлэг багийн төв бий. Төвөөс 35 км-т байдаг. Заамар сумын төвийн ерөнхий төлөвлөгөө хийгдсэн. Ерөнхий төлөвлөгөө хэрэгждэггүй. 2019 онд сумын ерөнхий төлөвлөгөөг шинээр хийнэ. Шаардлага хангадаггүй. Орон сууцны 1м² 1000000 43-45 м² орон сууцтай. Шилжилт хөдөлгөөн ихтэй. 20 гаруй ААН ажиллаж байна. 300 нь Заамар сумын бусад нь шилжин ирээд байгаа. Аялал жуулчлалын хувьд Цогт хун тайжын холбогдолтой үзэх сонирхох газрууд бий. Жуулчны 1 баазтай. Амралт сувилал нуурын шавар байдаг энэ нь эмчилгээний хосгүй чанартай юм.

Хүрээлэн буй орчин уурхайн бүсэд тоосжилт, машин тэрэгний хөдөлгөөн их. 2016 онд эмнэлгийн үзлэгт хамруулсан үр дүн нь уушигны өвчлөл өндөр гарсан. Туул голын бохирдол их, Гольдрол сольсон голын хамгаалалтын 50м эргийн шугам үйлчилдэггүй, мөрддөггүй. Мэргэжлийн хяналт, байгаль орчны хяналтаар ирдэг боловч үр дүнгүй.

Газар тариалан 12000 га эргэлтийн талбайтай 1 баг нь Тосон баг

3-р баг уурхайтай. 2-р баг МАА-н баг байсан боловч 21000 га-д алт олборлох зөвшөөрөл өгсөн эсэргүүцээд шүүхээр шийдүүлж байна. Эрдэнэсийн эрин ХХК

22400 малтай малын бэлчээр байхгүй болох эрсдэл үүсээд байна. Боловсон хүчний хангамж муу. Нутгийн хүмүүс нутагтаа ирдэггүй. Орон тоогоор ажиллаж байна. Гэвч чанарын асуудал муу. 12 жилийн 320 хүчин чадалтай сургуульд 650 хүүхэд суралцаж байна. Өртгөтгөл барих талаар яригдаж байна. 9 жил 500 гаруй суралцагчтай, 340 хүүхдийн хүчин чадалтай хэтэрсэн. Хогны татвар сумандаа үлддэг. Аймгийн төсвийн орлогын 40 хувийг бүрдүүлдэг боловч эргээд төсвөөс бусад сумдтай адил төсөв авдаг.

Өмнөговийн жишгээр Заамар сумыг хөгжүүлэх сан байгуулсан. Томоохон аж ахуйн нэгжүүдээс жилд 100 сая төгрөгний хөрөнгө оруулалт хийхээр болж өнөөдрийн байдлаар 380 сая төгрөг орсон. Баялагийн сангийн жишгээр хөгжүүлэх бодлого барьж байна. Нийгмийн хариуцлагын хүрээнд ААН-үүдээс мөнгө шаардаж болохгүй гэсэн чиглэл өгдөг. АТГ-аас зөвлөгөө авсан. Хайлааст баг 2500 гаруйхан хүн амтай. Сумын төвөөс их хүн амтай алт хөтөлбөрөөр сум жишгээр байгуулсан. Уурхайн тосгоныг томруулах шаардлага байхгүй. Нөөц дууссан тохиолдолд нүүх шаардлага гарах магадлалтай.

2017 оны эхээр ажлын хувцасны үйлдвэр байгуулсан. Ажлын гутлын цех байгуулагдсан. Заамар сумын уран зургийн галерей байгуулан ажиллаж байна. Бүрэн сумтай шефийн харилцаатай. МУ-ын хэмжээнд суманд анхны галерейг байгуулсан. ХАА-н чиглэлээр уурхайг махаар хангах бодлого барьж байна.

Тулгамдсан асуудал:

- Голын гольдролд уурхайн ашиглалт явуулж хууль зөрчиж байна. Эвдэрсэн газар ихтэй.

6. ТӨВ АЙМГИЙН ЦЭЭЛ СУМ

Тамгын газрын дарга Түвшинжаргалтай уулзаж холбогдох танилцуулга уулзалт хийлээ.

Өнөөгийн байдлын танилцуулга: Сумын хувьд 2684 хүн амтай 5 төрлийн байгууллага бий. Газар тариалан давамгайлсан сум 76 ААН –тэй. 5 багтай үүнээс хөдөөгийн 2 төвийн 3 баг бий. Хадлангийн салаа 70 гаруй гардаг. Элсэн цагаан орон нутгийн тусгай хамгаалалттай. УБ-186 км. нийт 2600 хүн амтай. Ерөнхий төлөвлөгөөг Арт констракшн ХХК боловсруулсан

Аялал жуулчлалын хувьд Маршрут байхгүй жуулчны газар амралт сувилал байхгүй. Хүүлээ хаан гэсэн улсын тусгай хамгаалалттай газар бий. Хадны сүг зураг бичээс орон нутгийн хамгаалалттай болон байгалийн түүхийн дурсгалт газрууд бий. Хилийн цэсийн маргаан багатай, уул уурхай байхгүй, эрүүл мэндийн төв 3 их эмчтэй. Төрийн байгууллагын 3 сул орон тоо бий. Эмчийн тогтвор суурьшил муу 8 ортой эмнэлэг, ЭМТ 19 орон тоотой. 12 жилийн сургуультай, 552 сурагчийн хүчин чадалтай бөгөөд давсан. Улсын төсөвт 520 хүүхдийн дотуур байр тусгагдсан. Багахангай-Угтаалцайдам-Цээл чиглэлийн хатуу хучилттай авто зам тавих чиглэл бий. Ану сервис ХХК төсөвт байгууллагууд дулаанд холбогдсон. Эрчим хүчээ Дарханаас авдаг.

Сумын төв цэвэр бохир усны шугам сүлжээгүй. Багшлах боловсон хүчин хангалттай. Үйлдвэрлэл ОНХС ахуйн үйлчилгээний барилга баригдсан. Нарийн боовны цех, оёдлын цехтэй

7. ТӨВ АЙМГИЙН СЭРГЭЛЭН СУМ

Сумын газрын даамал М.Аззаяатай судалгааны багийн гишүүд болох БХТ-ийн ХАНБНСТХ-ийн дарга С.Давааням, Б.Батхишиг, Г.Балжмаа, Г.Баттуяа, Б.Идэрхангай, Б.Ганпүрэв нар уулзалт хийж МУ-ын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн талаархи танилцуулгыг хийж сумын одоогийн нийгэм эдийн засгийн байдлын талаар мэдээлэл авч харилцан мэдээлэл солилцож ажиллав.

Сумын өнөөгийн байдлын товч танилцуулга: Шинэ нисэх онгоцны буудал баригдаж байна. Мөн дагуул хот, Майдар сити хот 12 000 га газрын улсын тусгай хэрэгцээнд авсан. Ирээдүйд хотоос сум руу чиглэсэн хөгжлийн бодлого их яригдаж байна. Нийт 6200 иргэд газар өмчлүүлээд байна. Үүнээс 46 хувь нь Сэргэлэн сумын иргэд бусад 54 хувь нь улаанбаатар хотын иргэд эзэлдэг. Сүүлийн жилүүдэд газар өмчлөлийн өргөдөл их ирдэг болсон яг газар дээрээ амьдарч байгаа айл байхгүй хоосон газар боловч газрын санд бол өмчлөгдсөн. Мөн өмчлөлөөс гадна эзэмшлийн үйлдвэр үйлчилгээний зориулалттай газар их. Биржийн мэдээлэл дээрээс үзвэл нэг зуслангийн газрын зах зээлийн үнэ 1 сая төгрөг байдаг. Тодорхой үнэ байхгүй. Газрын үнийг дуудлага худалдааны анхны үнээр тооцдог. Ерөнхий төлөвлөгөө хийгдэж байгаагүй. 2019 оны аймгийн төсөвт ерөнхий төлөвлөгөө хийгдэхээр тусгагдсан . Сум 5 багтай. Мал аж ахуй чиглэсэн сум учир малчид ихтэй. Хүүхдийн хамран сургалт маш доогуур дийлэнх хүүхдүүд аймгийн төвд ирж боловсолын үйлчилгээ авдаг. Жуулчны 5-6 бааз үйл ажиллагаа явуулж байна. Ашиглалтын лиценз эзэмшдэг 11 аж ахуй нэгжтэй, алт, хайрганы нөөцтэй. Ус хангамж гүний худгаас авдаг. Төсвийн байгууллага тусдаа худагтай. Нэгдсэн халаалтын системд холбогдогдоогүй ба бүгд бие даасан халаалттай. Нэгдсэн инженерийн шугам сүлжээ байхгүй. Соёлын төв халуун тенээр, сургууль, цэцэрлэг уурын зуухаар, захиргааны байгууллага цахилгаараар халдаг. Хүүхдийн сувилал, гэр бүлийн 1, ахмал настны 1 амралт үйл ажиллагаа явуулж байгаа. Боловсон хүчний хангамж хүрэлцээтэй, 9 жилийн сургуультай 320 хүүхдийн хүчин

чадалтай , энэ жил нийт 70 хүүхэд бүртгэгдэж суралцаж байгаа хүүхдийн тоондоо таарсан багштай. 10 хүний ортой шинэ эмнэлэгтэй. 50 хүүхдийн 2 цэцэрлэгтэй анги дүүргэлт их сургуульд сурахдаа аймгийн төв рүү шилждэг. Иргэний бүртгэлийн хувьд нөхөр нь сумандаа бүртгэлтэй боловч эхнэр хүүхэд нь Налайх дүүрэгт бүртгэлтэй тэндээ төрийн үйлчилгээ авдаг асуудал байдаг.

Тулгамдсан асуудал.

- Сумаас аймаг руу шилжилт хөдөлгөөн их. Сургууль хүчин чадалтай боловч суралцагч байхгүй.
- Гэр бүлийн гишүүдийн бүртгэл 2 талд хийгддэг учир мал тооллого зэрэгт хүндрэл гардаг

V. ДҮГНЭЛТ

1. Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоо алдагдсан байна. Тухайлбал нэг хүнд ногдох газар нутгийн хэмжээгээр дэлхийд тэргүүлдэг хэрнээ нийт хүн амын нэг хотод ногдох хувиар дэлхийд тэргүүлж байна. Дэлхийн хамгийн их агаарын бохирдолтой Улаанбаатар хотод нийт улсын хүн амын 50 шахам хувь амьдарч байгаа нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд ноцтойгоор нөлөөлж байна. Иймд нийслэлийг дахин төлөвлөж хөгжүүлэхээс илүүтэйгээр дагуул хот болон дунд хотод хүн амьн шилжилт хөдөлгөөнийг татах хүчин зүйлсийг байршуулж, хэт төвлөрлийг сааруулах шаардлагатай байна.
2. Хүн амын шилжилт хөдөлгөөний том хотын онол Монгол Улсад хамгийн тодоор хэрэгжиж байна. Тухайлбал энэхүү онолоор хамгийн том хот нь хоёрдогч хотоосоо хүн амын тоо нь 2 дахинаас илүү их бол том хотыг чиглэсэн шилжилт хөдөлгөөн зайлшгүй явагддаг гэж үздэг. Харин энэ харьцаа Монголд 15 дахин их буюу энэ үзүүлэлтээр дэлхийд эхний 4-т орж байна.
3. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийн хувьд нэг түвшин доторхи нэгжүүд нь хүн амын тоо, газар нутгийн хэмжээгээр хоорондоо эрс ялгаатай байна. Тухайлбал аймгаас том сум, сумаас том баг, дүүргээс том хороо байсаар байна. Иймд бусад улс орнуудын жишгээр хүн амын тоогоор шалгуур тогтоож өгөхгүй бол цаашид ч энэ ялгаатай байдал нэмэгдсээр байх төлөвтэй байна.
4. Монгол Улсад хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдал орон зайн хувьд ялгаатай байна. Нийслэл, аймгийн төв хот зэрэг суурин газруудад ажилгүйдлийн түвшин өндөр байгаа бол сум, орон нутагт ажилгүйдлийн түвшин бага байна.
5. Хүн амын төвлөрөл багатай хөдөөгийн сум, орон нутагт эрүүл мэнд, боловсрол, төрийн захиргаа зэрэг төрийн үйлчилгээний чанар хүртээмж муу байна. Тухайлбал зарим сум, орон нутагт мэргэжлийн эмч, багш, галч, төрийн захиргааны ажилтан нарын ажлын байранд ажиллах хүн олдохгүй байна.
6. Хот суурин газруудын хувьд ч хүн амын тоо болон газар нутгийн хэмжээгээр ялгаатай байна. Суманд харьяалагдаж байгаа хотуудаар аваад үзвэл хамгийн бага газар нутагтай Архангайн Цэцэрлэг хот бүхий Эрдэнэбулган сумаас Дундговийн Мандалговь хот бүхий Сайнцагаан сумын газар нутгийн хэмжээ 200 дахин зөрүүтэй байна.
7. Нийслэлийг чиглэсэн хүн амын хэт төвлөрлийн эрчим сүүлийн жилүүдэд саарч байгаа хэдий ч нийслэлийг чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөн үргэлжилсээр байна.
8. Хүн амын шилжилт хөдөлгөөнийг татах хүчин зүйлс нь нийслэл Улаанбаатар хотод хэт төвлөрсөн тул хүн амын хэт төвлөрлийг сааруулахад бэрхшээл учруулж байна. Иймд хүн амын шилжилт хөдөлгөөнийг татах хүчин зүйлсийг нийслэлээс сарниулан дагуул хот болон дунд хотуудад төвлөрүүлэх шаардлага үүсч байна.
9. Дэд бүтцийн үндсэн тэнхлэгийн дагуух болон уул уурхайн аж үйлдвэрлэл дагасан Замын-Үүд, Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд, Гурвантэс зэрэг сумдад хүн

амын суурьшил эрчимтэй явагдаж байгаа нь тэдгээрт засаг захиргааны болон хот тосгоны статусыг нэмэгдүүлж, тогтвортой хот байгуулалтын төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

10. Монгол Улсын нийт 350 гаруй хот, суурин газруудын 90 гаруй хувийнх нь хүн амын тоо 5000 хүрэхгүй байгаа нь олон улсын жишгээр тухайн суурин газарт жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих зах зээлийн багтаамж багатайгаас эдийн засгийн хувьд бие даан хөгжих чадавхи хомс байгааг харуулж байна.
11. Дэлхийн дулаарал бүхий уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр гадаргын усны нөөц багасч, бэлчээрийн экосистемийн доройтол нэмэгдэж байгаа нь хот суурин газрууд болон хөдөөгийн хүн амын усны хангамж, экосистемийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байна.

Ашигласан материалууд

1. Ном, товхимол, судалгааны тайлан, эрдэм шинжилгээний өгүүллүүд

- Аймгуудын Статистикийн хэлтэс. 2018. Статистикийн эмхэтгэл 21 аймаг – 2017 он
- Базаргүр Д. 2007. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн шинэчлэлийн нийгэм-эдийн засгийн газарзүйн тандах судалгаа.
- Баттүвшин Б. 2005. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийн шинэчлэл ба нийгмийн удирдлагын тогтолцооны эрхзүй, удирдлага, зохион байгуулалтын шинэчлэл.
- БСШУЯ, 2011, Боловсролын салбарын 2010-2011 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллийн эмхэтгэл
- ЗГХЭГ. 2006. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн үүсэл хөгжил, өнөөгийн байдал, шинэчлэл хийх саналын тухай.
- ЖАЙКА. 2016. Бүсчилсэн хөгжлийн нэгдсэн судалгаа
http://open_jicareport.jica.go.jp/pdf/12283339_01.pdf
- Монгол Улсын Засгийн газар. 2005. Аймгуудад хүргүүлсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн шинэ хуваарийн санал зураг, сэтгүүл.
- Монгол Улсын Засгийн газар. 2005. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийг шинэчлэх саналын тухай. Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн барьсан материал.
- Сономдагва Ц. 1998. Монгол УЛсын засаг захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт, шинэчлэлт.
- Үндэсний Статистикийн Хороо, 2011, Хүн ам, орон сууцны 2010 оны тооллого
- Үндэсний Статистикийн Хороо, 2011. Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2010.
- Үндэсний Статистикийн Хороо. 2008. Монгол Улсын хүн амын 2008-2030 оны хэтийн тооцоо
- Цэдэндамба Л, Х.Маам. 2000. Монгол Улсын Өрнөд бүс.
- Цэдэндамба Л. Р.Ринчинбазар, Д.Гансэлэм. Эдийн засгийн бүсүүдийн хөгжлийн тулгуур төвүүдийг илрүүлэн тогтоох арга зүйн асуудалд. Үндэсний Хөгжлийн хүрээлэн. Бүтээлийн эмхэтгэл.
- ШУА. Газарзүйн хүрээлэн. 2005. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг өөрчлөх саналын хувилбар
- Алтанбагана М., С.Давааням, Хэрлэнбаяр. 2016. Монгол Улсын хот байгуулалтын тайлан, БХБЯ-ны захиалгаар
- Давааням С., Д.Бямбаа. 2011. Монгол Улсын Хүн амын суурьшил, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа. Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны захиалгаар

Давааням С., М.Алтанбагана нар. 2011. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн шинэтгэлийн талаар харьцуулсан судалгаа, бодлогын оновчтой хувилбарууд, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны захиалгаар

Хоролжав Ц. 2011. Монгол орны хот байгуулалтын байгалийн нөхцөл

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар. 2018. Хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдал

Chuluun, T, Altanbagana M., Davaanyam S. & Ojima D. 2006. Vulnerability and adaptation options of the coupled human-environmental system to global change in Mongolia. Pages 148 In: A program of Earth System Science Partnership Open Science Conference on “Global Environmental Change: Regional Challenges”, Beijing, China.

Chuluun, T. 2005. A new administrative-territorial division of Mongolia as a mechanism to increase adaptive capacity to climate change. Pages 436 In: The 6th open meeting of the international human dimensions meeting of global environmental change on “Global environmental change, globalization and international security: new challenges for the 21st century” Conference book, Bonn, Germany.

Dexia, EU sub-national governments: 2008 key figures, 2009/2010 edition

Expert Group. 2010. Analytical study on optimal administrative-territorial structure for republic of Moldova.

2. Хууль эрхзүйн баримт бичгүүд

Монгол Улсын Үндсэн хууль. 1993

Засгийн газрын тухай хууль

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

Хот тосгоны эрхзүйн байдлын тухай хууль

Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохион байгуулалтын тухай хууль

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал. 2001

Баруун, Хангайн, Төвийн болон Зүүн бүсийн хөгжлийн хөтөлбөрүүд

Бүсчилсэн Хөгжлийн Хороо. 2005. Бүсчилсэн хөгжил гарын авлага.

ХАВСРАЛТ 1. Орон нутагт томилолтоор ажилласан байдал Томилолтоор ажилласан байдлын зургууд



Зураг 1. Төв аймгийн Бүрэн суман дахь хурлын үйл явц \Бүрэн сумын Засаг даргын орлогч, Бүрэн сумын газрын даамал болон ХАНБНСТХ-ийн дарга С.Давааням, мэргэжилтэн Г.Балжмаа, Г.Баттуяа, Б.Идэрхангай ХСДБСТХ-ийн мэргэжилтэн Б.Ганпүрэв нарын хамт



Зураг 2.Төв аймгийн Бүрэн сумын төв хэсэг



Зураг 3. Төв аймгийн Өндөрширээт суман дахь уулзалт \ Өндөрширээт сумын Засаг даргын орлогч болон ХАНБНСТХ-ийн дарга С.Давааням, мэргэжилтэн Г.Балжмаа, Б.Баттуяа, Б.Идэрхангай ХСДБСТХ-ийн мэргэжилтэн Б.Ганпүрэв нарын хамт\



Зураг 4.Төв аймаг Лүн сумын төв талбай



Зураг 5. Төв аймгийн Заамар суман дахь уулзалт /Заамар сумын ИТХ-ын дарга ,Заамар сумын засаг даргын орлогч, болон ХАНБНСТХ-ийн дарга С.Давааням, мэргэжилтэн Г.Балжмаа, Б.Баттуяа, Б.Идэрхангай ХСДБСТХ-ийн мэргэжилтэн Б.Ганпүрэв нарын хамт/



Зураг 6.Төв аймаг Заамар сумын төвийн хэсэг



Зураг 7. Төв аймгийн Цээл суман дахь хурлын үйл явц /Цээл сумын тамгын газрын дарга ХАНБНСТХ-ийн дарга С.Давааням/



